

УЛС ТӨР

С.ЧИНЗОРИГ: ДАХИЖ БИТГИЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТЭТГЭМЖЭЭР ОРОЛЦООРОЙ

II нүүрт

ДЭЛХИЙ

БНХАУ ДИПЛОМАТ ЯЛАЛТ БАЙГУУЛЛАА

VI нүүрт

Дугаарын **60** мөр

Галт тэрэг
ТОГЛООМ Биш...

Н.БАТЗАЯА

Сүүлийн үед зарим нэгэн жолооч нарын хийрхэл хэрээс хэтэрлээ. Өдөр бүр гардаг авто машины осол галт тэрэгний аймшигт осол болох дөхөв. Ингэж хэлсний учир гэвэл энэ сарын 17-нд хариуцлагагүй жолооч нарын буруутай үйлдлээс болж томоохон хэмжээний осол гарах шахсан. Тодруулбал, Замын цагдаагийн газрын баруун урд уулзварын төмөр замын гарам дээр хоёр автомашин тэгэн зогсоноос болж ачааны галт тэрэг метр хүрэхгүй зайд тулж ирэн зогссон. Чадварлаг машинист залуусын ачаар өнөөдөр хүн бүр алаг хорвоогийн нарыг харан гэртээ элэг бүтэн амьдарцаж байна. Хэрвээ машинистууд зайгаа буруу тооцоолж, нэг секунд л алдсан бол өдийд гурван хүн амиа алдаж, гурван хүний гэр бүл, аав, ээж, найз нөхөд гашуун нулимстайгаа холилдон суух байсан биз.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

МАН-д бүтэн итгэлээ, ОДОО БҮРЭН ХӨГЖҮҮЛЭХИЙГ НЬ ХАРЦГААЯ

Н.ПУНЦАГБОЛД

Орон нутгийн сонгууль энэ сарын 19-нд боллоо. Сум, дүүргийн төлөөлөгчдийг сонгох сонгууль. Ухаандаа ард түмэн бидэнтэй хамгийн ойр ажиллах анхны шатны нэгжийг сонгох сонгууль юм. Хорооны Засаг даргаас авахуулаад дүүрэг, сумын удирдлагууд энэ сонгуулийн дараа тодорч, ажлаа эхлэх учиртай. Хэдийгээр түүхэнд байгаагүй муу ирдтэй сонгууль болж, нийслэлд цөөнгүй хэсэгт дахин санал хураалт явагдаж байгааг эс тооцвол МАН ялалт байгуулчихлаа. Монгол Улсын 360 гаруй сумын 200 гаруйд нь МАН ялсан гэсэн урьдчилсан мэдээ гарсан.

Нийслэлийн есөн дүүргийн дийлэнхэд нь ч МАН ялалт байгууллаа. Энэ сонгуулийн өмнө МАН-ын гол баримталсан суртал ухуулга нь “Манай намд бүтэн итгэчих. Тэгвэл бид Монгол Улсыг бүрэн хөгжүүлж, та нарыгаа сайн сайхан амьдруулна” гэх өнцөг байсан.

Тэгвэл Монголын ард түмэн МАН-д бүтэн итгэл хүлээлгэлээ. Одоо ирэх дөрвөн жилд бүрэн хөгжүүлж чадах эсэхийг нь харах л үлдэж байна. Ер нь хаана хаанаа МАН-ыг сонгож, ирэх дөрвөн жилд зүтгүүлэх нь зөв байсан. Тэртэй тэргүй УИХ, нийслэл, 21 аймагт МАН үнэмлэхүй ялалт байгуулсан.

Үргэлжлэл нь III нүүрт



Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ **15400**

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ЗАСГИЙН ГАЗАР-100 ХОНОГ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР 100 ХОНОГТ

БОАЖЯ шинээр эмхлэн байгуулагдсан 100 хоногт бодит байдлаа дүгнэх, ирэх дөрвөн жилийн төлөвлөгөө зорилтоо гаргах, тулгамдсан асуудлуудаа шийдэх, УИХ, Засгийн газраар шаардлагатай хууль, тогтоомжуудыг батлуулах чиглэлээр идэвхтэй ажиллалаа.

БОАЖЯ-аас эмхлэн байгуулагдсан эхний 100 хоногт хийсэн ажлынхаа заримыг тоймлон хүргэе.

Монгол Улс Парисын хэлэлцээрт нэгдэн оров

СОР21-CMP11
PARIS 2015
UN CLIMATE CHANGE CONFERENCE

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй сааруулах, түүний үр дагаврыг бууруулах чиглэлээр дэлхийн улс орнууд идэвхтэй хамтран ажиллаж, 2015 оны арванхоёрдугаар сард Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Талуудын 21 дүгээр Бага хурлаар Парисын хэлэлцээр баримт бичгийг баталсан. Уур амьсгалын өөрчлөлт Монгол Улсад илүү хүчтэй тусч буйн нэг илэрхийлэл нь өнгөрсөн зун Ганга нуур ширгэсэн явдал юм. БОАЖЯ-наас Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын 2016 оны есдүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаар батлуулсан.

Үргэлжлэл нь IV нүүрт

EPSON
EXCEED YOUR VISION

L-СЕРИЙН ПРИНТЕРЭЭ АВААД

ХОРОО 10% ХӨНГӨВҮҮЛЖ АВААРАЙ

7575-3535 | www.pcmall.mn | /PCmallOfficial

ХААН банк				Худалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах		
АМ.ДОЛЛАР	2325.00	2339.00	ФУНТ	2799.00	2898.00	АМ.ДОЛЛАР	2327.00	2340.00		
ЕВРО	2505.00	2573.00	РУБЛЬ	35.90	39.00	ЕВРО	2490.00	2604.00		
ИЕН	22.19	22.77	ЮАНЬ	343.50	347.40	ИЕН	21.94	23.07		
								ЮАНЬ	343.50	347.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Дуучин
Г.Ариунбаатарт
“Чингис хааны
одон” хүртээнэ

Чингис хааны мэндэлсэн өдөр буюу Монгол бахархлын өдөр энэ сарын 31-нд тохионо. Энэ өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Төрийн бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлжээ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Төсвийн хүрээний мэдэгдэлд Уул уурхайн томоохон төслүүдийг эрчимжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, эдийн засгийг солонгоруулах замаар ДНБ-д эзлэх хувийг 2017 онд 23.4 хувь, 2019 онд 22.7, нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь 2017 онд 32.7 хувь, 2018 онд 30.9 хувь, 2019 онд 28.2 хувь байхаар тооцож, 2017 онд 9.9 хувь, 2018 онд 7.5 хувь, 2019 онд 5.5 хувь байхаар тусгагдсан байна. Мөн өнөөгийн үнэ цэнээр тооцсон улсын өрийн нийт хэмжээг 2017-2019 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаараас хэтрэхгүй байхаар тооцож, хуулийн төслийг боловсруулжээ.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

С.ЧИНЗОРИГ: ДАХИЖ БИТГИЙ ТӨРИЙН АЛБАН
ХААГЧДЫН ТЭТГЭМЖЭЭР ОРОЛДООРОЙ

Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэж гишүүдийн 70.9 хувийн саналаар тухай хуулийн төслийг хэлэлцэж бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлжээ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Төсвийн хүрээний мэдэгдэлд Уул уурхайн томоохон төслүүдийг эрчимжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, эдийн засгийг солонгоруулах замаар ДНБ-д эзлэх хувийг 2017 онд 23.4 хувь, 2019 онд 22.7, нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь 2017 онд 32.7 хувь, 2018 онд 30.9 хувь, 2019 онд 28.2 хувь байхаар тооцож, 2017 онд 9.9 хувь, 2018 онд 7.5 хувь, 2019 онд 5.5 хувь байхаар тусгагдсан байна. Мөн өнөөгийн үнэ цэнээр тооцсон улсын өрийн нийт хэмжээг 2017-2019 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаараас хэтрэхгүй байхаар тооцож, хуулийн төслийг боловсруулжээ.

Б.Чойжилсүрэн: Бондыг
бондоор санхүүжүүлэхээс
өөр эх үүсвэр алга

Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан “2017 оны төсвийн алдагдлыг 2.5 их наяд төгрөгөөр багтах болж байна. 2017, 2018 оны сорилт бол гадаад өрөө ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх вэ. 60 хоногийн дараа 580 сая ам.доллар төлнө. Арилжааны банкуудын дотоод өрөнд таван их наяд төлөх ёстой. Цаг хугацаа тулгала. Гэтэл төсвийн 2.5 их наядын алдагдлыг юугаар санхүүжүүлэх вэ. Том төслүүд шууд хөдлөөд эдийн засаг 3.8 хувиар өсөх үү. Төсвийн алдагдлаа ДНБ-ийн 10 хувь руу дөхүүлээд батлах юм бол зээлжих зэрэглэл буурна. Олон улсын зах зээл дээрээс босгох мөнгө маш үнэтэй босно. Эдийн засгийн өсөлтөө өөдрөг авсан хэрнээ орлого нь

600 тэрбумар өсөхөөр тооцож. Хэр бодитой төсөөлөл вэ. Төсвийн алдагдлыг бууруулах боломж байна уу. Төсвийн зарлагын реформын асуудлыг нэлээн ярьсан. Ирэх онуудад энэ тал дээр юу хийх вэ. Хийж байгаа таамаглал нь төсвийн төсөөлөл дээрээ хэр буув. Концессын гэрээний үнийн дүнг хэлж өгөөч, 2017, 2018, 2019 онд маш том зардал ирэх гээд байна. Тооцсон тооцоолол байна уу” гэдгийг тодрууллаа. Харин Сангийн сайд Б.Чойжилсүрэн “Төсвийн алдагдал хоёр их наядад хүрлээ гэлээ. Ийм нөхцөл байдалд Засгийн газар орсон. Тийм учраас 2016 оны төсвийн тодотголын алдагдлыг 18 хувьтай баталсан. Тодотгол хийгээгүй бол 28 хувьтай байсан. 2017 онд төсвийн алдагдлыг хоёр дахин шахам буулгаад оруулж ирсэн. Нэг зүйл ажиглагдсан нь орлого буурахаар зарлагаа бууруулаагүй, зээл авдаг гинжин хэлхээ явж иржээ. Одоо бид бондыг бондоор санхүүжүүлэхээс өөр эх үүсвэр



Гэрэл зураг Г.АРИУНБААТАРТ

алга. Засгийн газар хэд, хэдэн төрлийн хэлэлцээр хийж байна. Сүүлийн жилүүдэд төсвийн орлогыг хэт өндөр тавьдаг байсан, үүнээс болж нэг их наяд төгрөгөөр буурдаг байсан. Ийм учраас орлогыг илүү бодитой болгохыг оролдсон. Засгийн газар төсвийн зарлагын реформыг хийх гэж оролдсон. Найман төрлийн татварыг нэмэгдүүлж, хүн амын 2-3 хувьд хамаарах татвар оруулж ирсэн, батлуулж чадаагүй. Төсвийн зардал дээр тодорхой хэмжээний зардал бууруулахаар оруулж ирсэн ч УИХ хүлээж аваагүй. Өмнөх Засгийн газрын үед 1.8 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний концесс байгуулагдсан, 2017 оны төсөвт тодорхой хэмжээний зардлыг төсөвт суулган оруулж ирсэн” гэсэн хариулт өглөө.

Дарга нар нь чуулгандаа
сууж, ажил хэрэгч
баймаар байна гэв

УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшин “Засгийн газар том зорилтдоо хүрэхэд бүх юмаа дайчилж байж хүрнэ. Үрэлгэн зардлыг хасах талын юм Засгийн газарт дутаж байна. Зарим сайд төврдөг байшин шиг 10 өрөөтэй албан засагчид сууж байгаа. Манайхан хийгээгүй л дээ. Тэдгээрийг хурааж аваад сургууль, цэцэрлэг болгох хэрэгтэй. “Оюутолгой” улсын төсөвтэй тэнцэх хэмжээний орлого хийсэн хэрнээ зургаан хувьтай тэнцэх хэмжээний татвар л улсад төлж. Оюутолгойн 34 хувиас би битгий хэл ач гуч маань ч ашиг хүртэхгүй, Монголын өр болоод л яваад байхаар байна. Энийг яаж шийдэх вэ. Өнгөрсөн хугацаанд бие, биенээ баахан идсэн, ууснаар

нь дуудлаа. Буруутан нь хэн бэ гэдгийг тогтоох үйл явц дэндүү удаан байна. Дөрвөн сар өнгөрлөө, энийгээ тогтоогоод гаргаад ир. Тэр талаас “Танайхаас ч хүн оролцсон” гээд хэлээд байна. Манайхнаас оролцсон хүн байвал зарла. Толгойг нь илэхгүйгээр хариуцлагыг нь хүлээлгэ. Хэн ч байсан 461-д нь аваачаад асуух хэрэгтэй” гэв. Ц.Нямдорж гишүүний хувьд “Ирэх жилийн эдийн засгийн амьдралын шийдвэрүүдийг гаргах гэж байна. Тиймээс энэ байнгын хорооны дарга нар нь чуулгандаа сууж, гишүүдийн ярьж байгааг судалж, сонсоод, ажлын албаараа дамжуулан судалгаа хийлгээд ажил хэрэгч байх хэрэгтэй байна” хэмээн намын нөхөддөө шүүмжлэлтэй хандав. Учир нь УИХ-ын чуулганаар 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байхад хуралдаанд Төсвийн хорооны дарга, Эдийн Засгийн

хорооны дарга гээд байх ёстой дарга нар байхгүй байсантай холбоотой юм.

Б.Пүрэвдорж: Л.Элдэв-
Очир, Л.Энх-Амгалан нар
100 тэрбум төгрөгийг
улсад буцааж өгөөрэй

УИХ-ын чуулганы үдээс хойших хуралдаанаар Монгол Улсын 2017 оны төсвийн тухай, түүнтэй холбоотой хуулийн төслүүдийг хэлэлцсэн юм. Хэлэлцүүлгийн шатанд төрийн албан хаагчдад олгох 36 сарын тэтгэмж, хүүхдийн мөнгө, хамтын тэтгэвэр, хүүхэд харах үйлчилгээний асуудлыг нэлээд олон гишүүн хөндсөн. Тухайлбал, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат “Төсвийн орлогыг төсөөлөхдөө дутуу авсан байна. Зэсийн үнийг 66 ам.доллараар дутуу оруулж ирлээ, үүнээс 50 тэрбум төгрөг үлүү гарах тооцоолол бий. Нүүрсний үнийг өнөөдрийн байгаа үнээр буюу 50 ам.доллар гэж оруулж ирлээ, 70 ам.доллар байна. Төрийн албан хаагчдад олгох тэтгэлийг 36 сар талын юм Засгийн газарт дутаж хүртэл гэдэг юм битгий тавиагч ээ. 36 сар гэдэг тоог илэрхийлж байгаа шиг 10 өрөөтэй албан засагчид сууж байгаа. Манайхан хийгээгүй л дээ. Тэдгээрийг хурааж аваад сургууль, цэцэрлэг болгох хэрэгтэй. “Оюутолгой” улсын төсөвтэй тэнцэх хэмжээний орлого хийсэн хэрнээ зургаан хувьтай тэнцэх хэмжээний татвар л улсад төлж. Оюутолгойн 34 хувиас би битгий хэл ач гуч маань ч ашиг хүртэхгүй, Монголын өр болоод л яваад байхаар байна. Энийг яаж шийдэх вэ. Өнгөрсөн хугацаанд бие, биенээ баахан идсэн, ууснаар

нь дуудлаа. Буруутан нь хэн бэ гэдгийг тогтоох үйл явц дэндүү удаан байна. Дөрвөн сар өнгөрлөө, энийгээ тогтоогоод гаргаад ир. Тэр талаас “Танайхаас ч хүн оролцсон” гээд хэлээд байна. Манайхнаас оролцсон хүн байвал зарла. Толгойг нь илэхгүйгээр хариуцлагыг нь хүлээлгэ. Хэн ч байсан 461-д нь аваачаад асуух хэрэгтэй” гэв. Ц.Нямдорж гишүүний хувьд “Ирэх жилийн эдийн засгийн амьдралын шийдвэрүүдийг гаргах гэж байна. Тиймээс энэ байнгын хорооны дарга нар нь чуулгандаа сууж, гишүүдийн ярьж байгааг судалж, сонсоод, ажлын албаараа дамжуулан судалгаа хийлгээд ажил хэрэгч байх хэрэгтэй байна” хэмээн намын нөхөддөө шүүмжлэлтэй хандав. Учир нь УИХ-ын чуулганаар 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байхад хуралдаанд Төсвийн хорооны дарга, Эдийн Засгийн

хорооны дарга гээд байх ёстой дарга нар байхгүй байсантай холбоотой юм.

хэрэгжүүлж эхлэв гэж байна. Эдийн засаг гайгүй болсон нөхцөлд бүх хүүхэд, бүх ахмадаа олгоод явах бодлого баримтална. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж байгаа санаа” гэдэг хариултыг өгсөн юм. УИХ-ын гишүүн С.Чинзориг “Манай Сангийн яам 45 хоногийн дотор УИХ-аас хоёр өөр шийдвэр гаргуулах гээд байна. Учир нь Төсвийн тодотгол хэлэлцэж байхад та бүхэн 1-10 дугаар бүлэгт багцсан өрхийн хүүхдүүдэд хүүхдийн мөнгө олгоно гэж УИХ-ын тогтоол гаргуулсан. Одоо харин 2017 оны төсөв ярихаар босго шугамнаас доогуур орлоготой өрхийн хүүхдүүдэд хүүхдийн мөнгө олгуулна гэдэг шийдвэр УИХ-аас гаргуулах гээд байна. Ингэж болохгүй. Түүнчлэн Төрийн албан хаагчдын буцалтгүй тусламжтай холбоотой асуудлыг УИХ-аас Төсвийн тодотголоор ажилласан жигтэй нь уялдуулан олгож байхаар Төрийн албаны хуульдаа өөрчлөлт оруулж ирэхээр болж, тогтоол гаргасан. Гэтэл та бүхэн хялбарчлаад өмнөх хуучин байсан заалтыг нь сэргээгээд оруулаад ирсэн. Хэрвээ ийм байх юм бол 20 эсвэл 25 жил гэсэн босгыг авах ёстой. Нэг бол энэ босго гэх зүйлээ бусад бүх төрний албан хаагчдад ижил болго. Гэтэл одоо Төрийн захиргааны жинхэнэ албан хаагчдад нэг, хоёр жил ажилласан ч тэр 36 сарын тэтгэмжийг чинь авах гээд байна. Харин багш, эмч, цэргийн алба хаагчдад босго байгаад байна. Тиймээс энэ төрний алба хаагчдад олгож байгаа тэтгэмжтэй холбоотой асуудлыг бүр нэг бүрчлэн ойлголтыг нэгтгэх хэрэгтэй. Ер нь цаашдаа төрийн албан хаагчдад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжийн асуудлаар дахиж ийм зүйл УИХ-д

битгий оруулж ир” гэсэн юм. Харин Б.Пүрэвдорж “Хүүхэд харах үйлчилгээнд таван тэрбум төгрөг зарцуулж байсан. Гэтэл үүнийг хасчихлаа. Энэ үйлчилгээнд 1200 хүн ажиллаж байгаа түүний ар гэр гээд таван мянган хүн, 6700 хүүхэд хамрагдаж байсан. Тэгвэл эцэг, эхийг нь тоолоод үзэхээр Хүүхэд харах үйлчилгээнд нийтдээ 25 мянган хүн үр ашгийг нь хүртэж байна. Гэтэл үүнийг хасаад, оронд нь дөрвөн тэрбум төгрөгийн зардал бүхий дэд сайд нар буюу 13 хүний асуудлыг оруулж ирсэн. Ийм албан тушаалтнуудыг дэмждэг, ард түмнээ ялгаварладаг төсөв оруулж ирж байгаад харамсч байна. Одоо сонгуулиуд дуусчихлаа. Улс төржихөө болих шаардлагатай. Харж байхад УИХ-ын гишүүн Л.Элдэв-Очир, Л.Энх-Амгалан хоёр их улс төржиж байх шиг байна. Тавантолгой дээр тавьсан 270 км замыг 110 тэрбум төгрөгөөр “Эм Си Эс” компани барьсан. Харин дөрвөн жил ашигласны дараа түмэн нөхөөс

“Насны хишиг” шүүмжлэл дагуулж байгаа нь үнэн. Гаргаж чадаж байгаа эх үүсвэр нь 20 орчим тэрбум төгрөг. Энэндээ тохируулаад мөрийн хөтөлбөрөө

мянган хагархайтай болсон замаа 170 тэрбум төгрөгөөр улсад шахсан. Дөрвөн жилийн ашиглалтын бүтэц хасаад 70 тэрбум төгрөг болох байсан зам. Тиймээс Л.Элдэв-Очир, Л.Энх-Амгалан нар тэр 100 тэрбум төгрөгийг улсад буцааж өгөөрэй. Та нарыг их улс төржих тусам би гишүүдтэй холбоотой компаниудын асуудлыг тоо баримттай дэлгэх болно шүү гэдгийг хэлмээр байна” хэмээн бухимдсан юм.

Дашрамд дуулгахад, өнгөрсөн баасан гарагийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны дундуур хурлыг түр завсарлуулж, УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл хуралдсан юм. Энэ удаагийн УИХ-ын даргын зөвлөлийн хуралдаанаас шинэ долоо хоногт УИХ, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх хуулийн төслүүдийг гаргасан. Үүнд “Эрдэнэт”-ийн асуудал багтжээ. ОХУ-ын “Ростех” корпораци эзэмшиж байсан “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг “Монгол зэс” компани худалдан авах шатанд төрийн эзэмшил болох 51 хувийг эрх мэдэлгүй болгож хууль зөрчлөө гэх асуудлыг УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж тавьж, энэ асуудлыг судлахыг Засгийн газраас шаардсан юм. Харин Сангийн сайд Б.Чойжилсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, дүгнэлт гаргасан юм. Тус ажлын хэсгээс гаргасан дүгнэлтээр Сангийн сайд асан Б.Болорын “Эрдэнэт” үйлдвэртэй холбоотой гаргасан тогтоол нь хууль зөрчсөн байна хэмээн үзсэн. Мөн энэ асуудалтай холбогдуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт Авлигатай тэмцэх газарт хандаад байгаа. Тэгвэл шинэ долоо хоногт УИХ-аар уг асуудлыг хэлэлцэх болж байна.



Ц.Элбэгдорж машингүй, Ж.Эрдэнэбат гурван машинтай гэнэ

Шинээр сонгогдсон болон томилогдсон өндөр албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг АТГ-аас олон нийтэд дэлгэсэн билээ. Тэгвэл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарын хувьд Ц.Элбэгдорж машингүй, газаргүй гэнэ. Тодруулбал, жилийн орлого нь 88233.9 мянган төгрөг ажээ. Тэрбээр хоёр орон сууцтай бөгөөд машингүй, эзэмшил газаргүй юм байна. Харин мал сүргийн хувьд 28 адуу, найман үхэр, таван ямаа, 25

хоньтой. Түүнчлэн, 635 сая төгрөгөөр үнэлэгдэх үнэт эдлэлтэйгээс гадна хадгаламжиндаа 57 сая төгрөгтэй аж. Мөн зээлгүй бөгөөд Муштаг ХХК, Анх Эрдэнэ ХХК, Либерти дээд сургууль, АСУ ХХК, Женко тур бюро ХК, Ремикон ХК зэрэг байгууллагдах хувьцаа эзэмшдэг юм байна. Харин Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат гурван машинтай гэнэ. Түүний нийт орлого 99 сая төгрөг. Тэрбээр гурван байртайгаас гадна Toyota

Highlander, Toyota Land Cruiser 105, Lexus 570 маркийн гурван машинтай аж. Түүнчлэн, мал сүргийн тоо толгойн хувьд адуу-22, хонь-232, үхэр-32, нэг хурдан удмын адуутай бөгөөд 0.07 га эзэмшил газартай, 71 саяар үнэлэгдэх үнэт эдлэл, хадгаламжиндаа 21952.95 мянган төгрөгтэй гэнэ. Харин Сүүтэй ХХК, Хэрх-Илч ХХК, Хэрх-Өргөө ХХК, Гүн сан эрдэнэс ХХК зэрэг компанид хувьцаа эзэмшдэг юм байна.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**
88873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРИУУЖИН**
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхлэсэн **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

Галт тэрэг
ТОГЛООМ Биш...

МАН-Д БҮТЭН ИТГЭЛЭЭ, ОДОО БҮРЭН ХӨГЖҮҮЛЭХИЙГ НЬ ХАРЦГААЯ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Гэвч азаар машинист залуус шуурхай ажиллаж, 700 метр газраас хурдаа тооцоолон аймшигт осол гарахаас урьдчилан сэргийлж, бүрэн зогсч чадсан юм. Гэхдээ энэ явдал дахин давтагдахгүй гэх нөхцөл үгүй. Бас байнга аз тохионо гэж ч юу байх вэ дээ. Нэгэнт л сургалтад хамрагдаж, шалгалтыг нь өгөөд жолооч болох эрхээ авсан л бол замын хөдөлгөөний дүрмээ баримталбал дээргүй юу жолооч нар минь. Аль эсвэл их хотын түгжрэйд дүрмээ мартчихсан бол дахин нэг эргүүлээд харчихвал яасан юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд "Төмөр замын гарам нэвтрэх" талаар маш тодорхой зааж өгсөн байх юм. Тухайлбал, "Жолооч төмөр замын гарам дээр очихдоо аюулгүй байдал хангагдсан эсэхийг магадлана. Тэмдэг тэмдэглэгээ, хаалтын байдал, жижүүрийн заалтыг удирдлага болгоно" гэж нарийн заажээ. Мөн гэрэл нь анивчиж ассан, хаалт нь хаалттай, дууг дохио өгч байвал, жижүүр орохыг хориглосон дохио өгч байгаа үед гарам руу орж болохгүй гэсэн заалт ч байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд хүртэл галт тэрэгний гармаар гарахдаа хэрхэн зорчих талаар нарийн зааж өгчихөөд байхад жолооч нар замын түгжрэлээр түрий барьж хүссэн газар руугаа чихэх шаардлага алга. Энэ сарын 17-нд галт тэрэгний хөдөлгөөн зогсох болсон шалтгаан нь замын түгжрэл. Өөрөөр хэлбэл, замын түгжрэлээс болж хоёр машин галт тэрэгний гарман дээр тэгнэж зогсоод гагцхисан гэнэ. Тэдний хэлж буйгаар замын түгжрэл л энэ бүхэнд буруутай аж. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 12.5 дугаар зүйлд хүртэл түгжрэл саатал үүсвэл галт тэрэгний гарам руу орохыг хориглоно гээд заагдсан байхад хэдий болтол өөрсдийгөө хамгаалах гэсэн юм. Ямар ч түгжрэлтэй байсан галт тэрэг ирж байгаа дохио дуугарах үед эхний жолооч л зогсох шугамныхаа ард зогсчихвол бусад нь ч гэсэн дагаад зогсоно шүү дээ. Нэгэнт машин нисдэг болоогүйгээс хойш таны дээгүүр нисдэг урд чинь гарчихна гэж саидрах хэрэггүй. Зүгээр л жолооч бүр замын хөдөлгөөний тухай хуулиа дээдэлж, дүрмээ биелүүлчихсэн бол галт тэргэнд дайруулах шахах дээрээ тулахгүй л байсан.

Тэр бүү хэл гарам автомат саадаар тоноглогдсон учраас галт тэрэг 1000 метр хүртэлх зайд ойртон ирэхэд хаалт автоматаар буудаг гэнэ. Хаалт буухаасаа өмнө 8-12 секундын турш дуут дохиогоор жолооч нарт анхааруулга өгдөг байна. Ийм нарийн шат дараалалтай анхааруулга өгсөөр байтал галт тэрэгний гарам руу орж явж л байдаг. Галт тэрэг ойртох үед тухайн үеийн жижүүр машин доторх хүмүүсийг буу гэсэн ч буугаагүй аж. Галт тэрэг ойртон ирж байхад машинаасаа буухгүй гүрийнэ гэдэг бас л бөх зориг. Гэхдээ нарийн дүрэм, журам, анхааруулгатай төмөр замын гарам дээр түгжрэл ярьж зогсох ч хэрэггүй. Хэрэг явдал бишидвэл түгжрэл гэж ч хэлж амжилгүй хорвоог орхих болно шүү жолооч нар минь. Манай жолооч нарт хар зам дээр түгжрэлд уурсан хоорондоо уралдаж уран жолоодлого үзүүлдэг гэм бий. Хатуухан сануулахад төмөр зам бол та нарын хар зам дээрх түгжрэлээс гарах гэж улайрдагтай адил тоглоом биш. Төмөр замын ажил цаг, минут, секундээр явагддаг юм. Юмыг яаж мэдэх вэ дээ одоо ч гэсэн замын хөдөлгөөний дүрмээ нэг эргүүлээд харчихна биз. Мартсаныг чинь сануулаад өгнө.

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Завханыг эс тооцвол. Сая болсон орон нутгийн сонгуулиар Сүхбаатар аймагт АН нэг хүнээр давж гарч, олонхи болох шиг боллоо. Бусдаар бол МАН илт давуу ялчихаад байгаа. Ийм үед сум, дүүрэгт АН ялаад ч яах юм билээ. Яах вэ, нэг талаараа хяналт тавих боломж бий. АН ч сонгуулийн өмнө ийм утгатай сурталчилгаа хийсэн. Гэхдээ нөгөө талаас нь аваад үзвэл дөрвөн жилийн дараа улс орны байдал дээрдэггүй, эдийн засаг хол дээрээ босохгүй, одоогийн бахь байдаг хэвээрээ л байвал МАН барьцана биз дээ. "Бид дээрээ ажил хийх гэж, өчнөөн зөв бодлого гаргаж, зүтгэж ажилласан. Харамсалтай нь АН доод шатандаа бүх бодлогыг үгүйсгэж, ажил балласан" гээд яриад сууж байх магадлалтай юм. Тийм болохоор МАН-ыг аль ч шатанд нь сонгох нь зөв зүйтэй алхам байлаа. Дөрвөн жилийн дараа байдал хэвээрээ байвал тэдэнд чихэх хүн ч байхгүй. Эртнээс малтах нүх ч үлдээгүй. Сорөг хүчин гэж УИХ, нийслэл дээр алга. Тэд дураараа ямар ч бодлого гаргаад, хууль санаачлаад, боловсруулаад, олон хүний хүчээр түрээд батлаад, хэрэгжүүлээд явчихна. Одоо МАН-д ямар ч саад алга. Гагцхүү улс орныхоо төлөө өчүүхэн ч болов сэтгэл гарган зүтгэх л үлдээд байна. Тэдний ганц барих бодлого нь гуравхан сая хүнтэй, өчүүхэн жижиг эдийн засагтай, асар их баялагтай энэ улсыг хол дээр нь босгож, цашид жаахан шуурганд ганхаад байхааргүй болгох л байна. Түүнээс биш амлалтаа биелүүлнэ, мөрийн хөтөлбөртөө тусгасан бүгдийг хэрэгжүүлнэ гээд, төсвөө улам тэлж, эдийн засгаа алах юм бол тэгээд л өнгөрөө. Одоо л "идэж уух", авлига авах, оффшор данс руугаа Монголын мөнгийг зөөж, үрэн таран хийхийн хүслээ бага ч болов дараад, сэтгэл гарган зүтгэх л хэрэгтэй байна. Өнөөдрийг хүртэл тэд нам, эвсэл, фракци, нутаг ус, компани гээд бүхий л ашиг сонирхлоороо талцаж, энэ улсын хөрөнгө мөнгийг "салтаа" хавьдаа нуулаа. Хэдэн үеэрээ барж идэхээргүй хөрөнгөтэй боллоо, энэ улстөрчид. Одоо эрх биш нэг ханаж, цадаа байлгүй дээ. Нэг хүн 5,6 байртай, хэдэн арван машинтай, компанитай байна. Гадаадад хэдэн саяар тоологдох ам.долларын хадгаламжтай, үнэт зүйл нь гэхэд тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа. Тэгээд одоо улсаа бодох цаг болсон юм биш үү. Ард түмэн тэгж ч итгэж МАН-д итгэл хүлээлгэлээ. Гагцхүү энэ намын улсаа бүтэн хөгжүүлэхийг хүлээхээс. Гэхдээ зөв хөгжүүлэх хэрэгтэй байна. Төрийн залгамж чанарыг хадгалах хэрэгтэй. Өмнөх удирдлагуудаас хэрэгтэй, зөвийг нь үлдээмээр байгаа юм. Мөн олоод, өөрсдөө хумслаад үлдсэн хэдэн төгрөгөө дэмий халамж байдлаар тараамааргүй байна. Монгол Улсад төрсөн энэ гурван сая хүнд сайхан амьдрах заяа байх ёстой биз дээ. Хэрвээ МАН-ынхан минь, бүтэн итгэж



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

байхад бүрэн хөгжүүлж чадахгүй бол дараагийн сонгуулиар нусаа хацартаа наана шүү. Сая орон нутгийн сонгуулиар яав. УИХ-ын сонгуульд ялалт байгуулаад, албан тушаалын Засгийн газар байгуулснаасаа хойш МАН-ынхан юу хийв. Бараг л юм хийж чадсангүй. Тиймдээ ч ард түмний итгэл алдарч эхэлж байна. Энэ нь 360 гаруй сумын 10 гаруйд нь АН ялалт байгуулснаас харагдана. Өмнө нь хэзээ ийм олон суманд АН ялалт байгуулж байсан билээ. Өнгөрсөн 2012 оны сонгуулийг эс тооцвол. Өдийг хүртэл МАН л бүх сум, дүүрэг, ер нь хаа сайгүй л төр барьж байсан. Тэгвэл одоо ард түмэн хэн юм хийж чадсан, улс орныг хөгжүүлээнд нь саналаа өгдөг болж. Хэдхэн төгрөгт хууртагддаг цаг өнгөрч байсан. Өдөр ирэх тусам иргэд

мэдээллийг хурдан шуурхай авч, түүнийгээ өөрсдөө боловсруулж, зөв бурууг нь ялгаж, салгадаг болчихлоо. Засгийн газар 100 хоногт юу хийв. Өмнөхтэй харьцуулахад ямар байв. Зөв алхам хийв үү, буруу байв уу гэдгийг ухаж ойлгодог болсон. Одоо сонгуулийн өмнө жаахан мөнгө өгөөд бүхнийг болгочихдог цаг өнгөрсөн байна. АН "сайн хувьцаа" гээд мөнгө тараасан, тэглээ гээд яав. Амжилтад хүрсэнгүй. МАН хүүхдийн мөнгийг гацааж байгаад сая сонгуулийн өмнө гурван сараар нь өглөө. Тэгээд яав, иргэд өөрсдийнхөөрөө л сонгож байна. Дээрээс нь залуучуудын итгэл алдарч, дургүй нь хүрч, Монголоос дүрвэх дээрээ тулж байна шүү дээ. Тийм болохоор одоо энэ улсыг хөгжүүлэх хэрэгтэй байна. Өрнөөс өрний

хооронд амьдардаг айл шиг байгаад дургүй нь хүч байна, залуусын. Тийм болохоор бүрэн хөгжүүлнэ гэсэн амандаа хүрээрэй гэж хичээгүйлэн захиж байна, МАН-ынхан минь. Нэг хэсэг нь гадаадад хэдэн саяар нь ам.доллар аваачиж хадгалдаг, нөгөө хэсэг нь хоногийн хоолондоо санаа зовдог улс байсаар байх юм уу. Яах вэ, та нар мөнгөө хаана авч хадгалж, түүнийгээ мартаж, санана уу, хамаа алга. Хамгийн гол нь ард түмэн чинь хоногийн хоолондоо санаа зовдог биш, авсан цалингаараа сайхан амьдарчихдаг л болчихвол боллоо. Үүний төлөө л иргэд бүтэн итгээд байгаа юм шүү. Хэрвээ чадахгүй бол дараагийн сонгуулиар "нусаа хацартаа наагаад", цөм ялагдаад, гудамжинд гарч лааз өшиглөхдөө бэлтгэнэ биз.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



“Тиймдээ ч ард түмний итгэл алдарч эхэлж байна. Энэ нь 360 гаруй сумын 10 гаруйд нь АН ялалт байгуулснаас харагдана. Өмнө нь хэзээ ийм олон суманд АН ялалт байгуулж байсан билээ. Өнгөрсөн 2012 оны сонгуулийг эс тооцвол. Өдийг хүртэл МАН л бүх сум, дүүрэг, ер нь хаа сайгүй л төр барьж байсан. Тэгвэл одоо ард түмэн хэн юм хийж чадсан, улс орныг хөгжүүлээнд нь саналаа өгдөг болж. Хэдхэн төгрөгт хууртагддаг цаг өнгөрч байсан. Өдөр ирэх тусам иргэд

Эгвийн засагч
Ч.Омгочуу

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

МЭДЭЭЛЭЛ

ЗАСГИЙН ГАЗАР-100 ХОНОГ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР 100 ХОНОГТ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ингэснээр Монгол Улс Парисын хэлэлцээрт дэлхийн улс орнуудаас эхний 24 дүгээрт нэгдсэн орон болов. Энэ аравдугаар сарын 5 гэхэд АНУ, БНХАУ, Энэтхэг, Европын холбоо зэрэг дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 55-аас дээш хувийг гаргадаг нийт 81 улс орон нэгдсэнээр Парисын хэлэлцээр хугацаанаасаа өмнө буюу ирэх 11 дүгээр сарын 4-нд хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхлэхээр болсон. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудал даян дэлхийн хурц асуудал болсныг, нүүрстөрөгч багатай хөгжлийн шийдэл нэн чухал болохыг илтгэж байна. Манай улс Парисын хэлэлцээрт нэгдэн орсноор уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, хөгжиж байгаа улс орнуудад санхүү, техник технологи, арга зүйн дэмжлэг туслахаа үзүүлэх механизмуудад хамрагдах боломж бүрдсэн. НҮБ-ын Уур амьсгалын ногоон санд жил бүр 100 тэрбум ам.доллар хуримтлуулж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээнд зарцуулж эхлэх гэж байна. БОАЖЯ энэ сантай идэвхтэй хамтран ажиллахаар хэд хэдэн төслийн санал хүргүүлсэн. Мөн тус сангаас үзүүлж байгаа бэлэн байдлыг хангах дэмжлэгт бүрэн хамрагдаж Үндэсний хэрэгжүүлэгч нэгжүүдтэй болохоор ажиллаж байна. Монгол улс 2030 он гэхэд уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан болсон хүлэмжийн хийн ялгаралтаа 14 хувиар бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Олон улсын байгууллагыг үүсгэн байгуулна

Олон улсын тогтвортой аялал жуулчлал, ядуурлыг бууруулах байгууллагыг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийн төслийг БОАЖЯ-наас боловсруулан УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлэн дэмжигдлээ. Олон улсын Тогтвортой аялал жуулчлал – Ядуурлыг бууруулах байгууллага нь анх “СТ-ЕП сан” нэртэйгээр 2004 онд БНСУ-ын Засгийн газрын санаачилгаар НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын хүрээнд үүсгэн байгуулагдаж, гишүүн орнуудад төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн байна. Уг байгууллагын үндсэн зорилго нь дэлхийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх, хөгжиж буй улс оронд ажлын байр нэмэгдүүлж ядуурлыг бууруулах, орлогын тэгш бус байдлыг багасгах, сайн засаглалыг бэхжүүлэх зорилтын хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийг олон улсын бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, олон улсын санхүүгийн байгууллагаас санхүүжилтийн дэмжлэг авч шийдвэрлүүлэхэд чиглэдэг. Энэхүү байгууллагын гишүүн орноор элсэн орсноор тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж эдийн засгаа төрөлжүүлэх төсөл хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг хангахад ихээхэн түлхэц болох бөгөөд гишүүнчлэлийн аливаа төлбөр төлөхгүй юм байна. “СТ-ЕП сан”-г олон улсын биеэ даасан олон улсын байгууллагын статустай болох саналыг ДАЖБ-ын Ерөнхий Ассамблейн 20 дугаар чуулганы үеэр нийт 156 гишүүн орон дэмжжээ.

Орхон голын бохирдлыг бууруулав



БОАЖЯ-ын сайд Д.Оюунхоролор ахлуулсан УИХ-ын гишүүд, УУЯ, МХЕГ, орон нутгийн холбогдох албаныхны хамтарсан баг Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт 2016 оны есдүгээр сарын 3-4-ний өдрүүдэд ажиллав. Орхон голын эхэнд алтны шороон ордын олборлолт явуулж буй аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрөө байршуулаагүй, усны бохирдлоос хамгаалах далан хаалтныг байгуулаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу үйл ажиллагаа явуулж байсан учраас хууль, журам биелүүлэх шаардлага тавьж, үйл ажиллагааг зогсоосон. Улмаар БОАЖЯ, Мэргэжлийн хяналт, орон нутгийнхны хамтарсан эрчимжүүлсэн ажлын хэсэг газар дээр нь ажиллаж, хууль, тогтоомжийг биелүүлэх хатуу шаардлага тавьж ажилласан. Ажлын хэсгийн ажлын үр дүнд аж ахуйн нэгжүүд хаалт далангаа барьж, гол руу цутгах бохир усны хэмжээ багассан. Цаашид тэдгээр аж ахуйн нэгжүүдийг хууль бус үйл ажиллагаагаа таслан зогсоогоогүй тохиолдолд тусгай зөвшөөрлийн цуцлах хүртэл арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Ашиглалтын лицензийг цуцлуулах саналыг хүргүүлэв

Хэнтий аймагт Онон, Балж голын цэвэр усны нөөц, ойн сан бүхий газарт “Айвуун тэс”, “Ю энд Би”, “Гутайн даваа” ХХК гэсэн гурван компани хууль зөрчиж олборлолт явуулж байгаа гэсэн мэдээллийн дагуу БОАЖЯ-наас хяналт шалгалт хийсэн. “Ю энд Би” ХХК нь хууль тогтоомж зөрчсөн хариуцлагүй үйл ажиллагаа явуулж байсан учраас ашиглалтын лицензийг цуцлуулах саналыг Ашигт малтмалын газарт хүргүүлсэн. Тус компани Ойн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас 0.9 га талбайд учирсан хохирлыг зохих журмын дагуу нөхөн төлүүлэх арга

хэмжээг авахаар болсон. БОАЖЯ-ны хувьд хууль тогтоомж зөрчигсдөөс хариуцлага нэхэх эрх зүйн боломж байдаггүй. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1-д зааснаар байгаль орчны хяналтыг Мэргэжлийн хяналтын байгууллага тавьдаг. Яам зөвхөн хууль тогтоомж зөрчиж буй тухайн аж ахуйн нэгжийн лицензийг цуцлуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлдэг. Түүнчлэн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд болон газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, тэдгээрийг чадавхижуулах чиглэлээр БОАЖЯ-наас тодорхой үүрэг даалгавар бүхий албан тоотыг УМБГ, ЭЦГ, МХЕГ, аймгуудын БОАЖГ-уудад хүргүүлэв.

Ганга нуураа аврахаар ажиллав



Ганга нуур ширгэж буй асуудлыг тодруулж, шийдвэрлэх арга замыг нарийвчлан тодорхойлох зорилгоор БОАЖЯ-аас томилогдсон ажлын хэсэг, орон нутгийн харьяа байгууллагуудын төлөөлөлтэй газар дээр нь ажиллаж нуурын ус уур амьсгалын өөрчлөлт, хэт халалт, малын тоо толгойн олшролын улмаас ширгэснийг тогтоосон. Иймээс нуурын усны тэжээгдэх эх үүсвэрийг сэргээн, ширгэлтийг багасгах, зогсоох арга хэмжээг авахаар БОАЖЯ-ны ажлын хэсэг санал боловсруулан тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Эхний ээлжинд Ганга нуур, түүнийг тэжээдэг булгийг хашаажуулах, орон нутгийн хөрөнгөөр бэлчээр усжуулалтын зориулалттай гүний худаг гаргах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулаад ажиллаж байна. Тодорхой арга хэмжээ авсны үр дүнд болон тухайн бүс нутагт орсон борооны ачаар есдүгээр сарын сүүлч гэхэд Ганга нуурын ус сэргээд байна. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн А/58 тоот тушаалаар нуурын усны балансын судалгаа хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Хөрсний бохирдолтой тэмцлээ

Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь оршин сууж байгаа гэр хорооллын 190 гаруй мянган өрхийн ариун цэврийн байгууламжийн 80 хувь нь доторлогоогүй, стандартын шаардлагад нийцэхгүй байгаа нь ус, хөрсний бохирдлын гол эх үүсвэр болж, халдварт өвчин дэгдэх суурь нөхцөл болж байна. Иймээс БОАЖЯ-наас Улаанбаатар хотын хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр олон улсын байгууллага, улс орнуудад төслийн санал хүргүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох арга хэмжээ авч байна. 2017-2020 онд хэрэгжих Азийн хөгжлийн банкны гурван сая ам.долларын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын гэр хорооллын 8000 өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах жиншиг төсөл хэрэгжүүлэх, цаашидад БНХАУ, Мянганы сориллын санд асуудлыг тавьж хотод төдийгүй орон нутагт хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төслийн хүрээнд Чингэлтэй, Баянзүрх дүүргийн зарим хороонд экологид ээлтэй ариун цэврийн байгууламж суурилуулах юм.

Хатан Туулаа хамгаалж ажиллав

“Байгаль хамгаалах намрын сарын аян”-ы хүрээнд БОАЖЯ, Нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд хамтран, зарим их, дээд сургуулийн оюутнуудын хүч, оролцоотойгоор өнгөрсөн 10 дугаар сарын 1-нд Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэр, Туул, Сэлбэ голын эргийн дагуух хог хаягдлыг цэвэрлэлээ. Туул голын эрэг рүү машинтай орж олон салаа зам үүсгэн талхлах, хог хаягдал хаяж бохирдуулахаас гадна хүйтний улиралд харзанд орох, зуны улиралд усанд орох үеэр хүний амь нас эрсдэх тохиолдлууд нэлээд гарсаар байна. Иймд БОАЖЯ, Туул голын сан газрын захиргаанаас санаачлан Туул голын хамгаалалтын бүс дагуу Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийн талаарх танилцуулга бүхий 300 ширхэг самбар, голын эрэг рүү машинтай орохыг хориглосон 10 ширхэг самбар, үер усны болзошгүй аюулаас сэргийлсэн зургаан самбарыг Туул голын эрэг дагуу байрдууллаа. Өнгөрсөн урин дулааны улиралд Туул голын дагуу дөрвөн удаагийн эргүүл шалгалтыг хийж, нийт 200 гаруй иргэдэд голын усанд машин угаахгүй байх, хог хаяхгүй байх, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар анхааруулж, хууль сурталчилж ажиллалаа. Туул голыг бохирдуулж буй арьс ширний үйлдвэрүүдийн талаар авах арга хэмжээний талаарх шийдвэрүүдийг цаашид хэрэгжүүлэх талаар БОАЖЯ-наас ХХААХҮЯ, мэргэжлийн хяналтын байгууллага, нийслэлийн ЗДТГ-тай хамтран ажиллаж байна.

Ус бохирдуулагчаас төлбөр авдаг болно

2012 онд батлагдсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоол, журам, жагсаалтыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болов. Засгийн газраас төлбөрийн хувь хэмжээг тогтоож, хаягдал усны төлбөрийг тооцох журмыг гаргах юм. Хаягдал усаа цэвэршүүлж чадалгүйгээр байгальд нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдээс харьцангуй

өндөр төлбөр авдаг болсноор аж ахуйн нэгжүүдийн хариуцлага дээшилж, байгаль хамгаалах хөрөнгийн санд тодорхой хуримтлал үүсэн. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу ус ашигласны төлбөрт 2013 онд 39.1 тэрбум, 2014 онд 34.5 тэрбум, 2015 онд 42.9 тэрбум дүнгээр төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан байна. 2016 оны төсөвлөөр 38.5 тэрбум төгрөг төсөвт төвлөрөхөөр байна. Иймд энэхүү хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, байгаль орчныг хамгаалах, бохирдлыг бууруулах, судлан шинжлэх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх, энэ хүрээнд усны эх ундаргыг хашиж хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах усан сан, хөв цөөрөм байгуулж, усны нөөцийг нэмэгдүүлэх зарчмыг БОАЖЯ-наас барьж ажиллаж байна.

Нүүдлийн аялал жуулчлалд Монгол Улс манлайлна



НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага /ДАЖБ/ БОАЖЯ, Дэлхийн хотуудын шинжлэх ухааны хөгжлийн холбоо олон улсын төрийн бус байгууллага, нийслэлийн ЗДТГ хамтран “Нүүдлийн аялал жуулчлал ба Хотуудын тогтвортой хөгжил” сэдэвт Торгоны замын олон улсын бага хурлыг 10 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Хуралд Торгоны замын гишүүн улс орон, НҮБ-ын ах дүү хотуудын холбоо, НҮБ-ын ДАЖБ-ын гишүүн орнууд болон олон улс, бүс нутгийн аялал жуулчлалын холбогдох байгууллагуудын төлөөлүүд, “Торгоны зам” хөтөлбөрийн 33 гишүүн улсуудын сайд нарын төлөөлөл болон хандивлагч олон улсын байгууллагууд оролцоо. Монгол Улс НҮБ-ын ДАЖБ-ын хөтөлбөр Торгоны замын аялал жуулчлалын дэмжлэгийн хүрээнд нүүдлийн аялал жуулчлалын брэндийг бий болгож, энэ чиглэлд манлайлагч байх алхмыг энэхүү хурлаар тавилаа. Монгол Улсын 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд заасан “Монгол Улс нь нүүдлийн соёл-аялал жуулчлалын төв болно” гэсэн зорилгыг хэрэгжүүлэх алхам ч энэ хурлаар тавигдлаа. Хурлын үеэр БОАЖЯ-ын сайд Д.Оюунхорол ДАЖБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Талиф Рифай тэргүүтэй олон улсын байгууллага, улс орнуудын төр, засгийн төлөөлөгчид, ГББ, хувийн хэвшилийн төлөөлөлтэй 10 гаруй албан уулзалтыг хийсэн бөгөөд энэ хэрээр Монгол Улсын аялал жуулчлалын салбарын гадаад харилцаа идэвхжлээ. ДАЖБ-ын зүгээс аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бэхжүүлэхэд тусалж, сургалт зохион байгуулах, нүүдлийн аялал жуулчлалын брэндийг бий болгоход манай улсад туслах, Монгол Улсын Үүд хот болсон Улаанбаатар аялал жуулчлалын цогц хөт байгуулахад тусалж дэмжихээр боллоо. БОАЖЯ-наас аялал жуулчлалын салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг ажлыг шат дараатай эхлүүлээд ажиллаж байна.

Ногоон модоо хамгаалах, ургуулах чиглэлээрх цогц бодлого



Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хамгийн үр дүнтэй арга болсон ногоон модоо хамгаалах, тарих, ургуулах чиглэлээр БОАЖЯ цогц бодлого хэрэгжүүлж байна. Сүүлийн 5 жилийн дүнгээр ойгоор бүрхэгдсэн талбай 864.5 мянган га-гаар багасч, ойрхог чанар 7.8 хувь болж 0,56 хувиар буурсан нь ойн түймэр, хөнөөлт шавьжны олшрол, хууль бус мод бэлтгэлтэй холбоотой. Ойг зүй зохистой ашиглах, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр есдүгээр сарын 28, 29-нд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг Сэлэнгэ аймгийн Түнхэл суманд зохион байгуулав. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд гэр хорооллын айл өрхийг хашаандаа мод тарихад уриалж, тэднийг дэмжих ажлыг БОАЖЯ-наас санаачлан эхлүүлээ. Уг ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 2, 21, 27 дугаар хорооны иргэдэд “Хашаандаа мод тарьж ургуулах нь” сургалтыг зохион байгуулав. Сургалтаар мод тарих аргачлал, усалгаа арчилгаа гэх зэрэг олон сэдвээр иргэдэд зөвлөгөө аргачлалыг зааж, тарьц суулгацаар хангаж ажиллав. Мөн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх багаж хэрэгсэл хуваарилж тухай БОАЖЯ-ын Сайдын 2016 оны А/19 тоот тушаалаар Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Увс, Архангай, Өвөрхангай, Төв, Дархан-Уул, Орхон зэрэг амйгуудын тиймрийн эрсдлийн бүсэд байрлах Сум дундын ойн анги, аймгуудын БОАЖГ болон зарим УГТХЗ-дад түймрээс хамгаалах, тэмцэх зориулалтын 3 нэр төрлийн нийт 260 гаруй багаж хэрэгслийг олгов.

БОАЖЯ Ахмадын зөвлөх үйлчилгээтэй болов



БОАЖ-ын сайдын есдүгээр сарын 19-ний өдрийн А/51 тоот тушаалаар яамны дэргэд Ахмадын зөвлөх үйлчилгээг бий болгов. Ахмадын зөвлөх үйлчилгээ бий болсноор байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх эрх зүй, эдийн засгийн зохицуулалтыг боловсронгуй болгох, ногоон хөгжил, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ахмадуудыг өргөнөөр оролцуулах боломжтой болж байгаа юм. Ахмадууд яамны албан хаагчдад ажлын дадлага туршлага, мэргэжлийн үр чадвараа өвлүүлэх боломжийг ч мөн олгож, энэ асуудлаар БОАЖЯ-ны Ахмадын хороотой гэрээ байгуулж ажиллахыг дээрх тушаалд тусгаад байна. Мөн БОАЖ-ын салбарын ахмадуудын ном, бүтээлийг эмхэтгэн хэвлүүлэх, түгээхэд дэмжиж тусалж ажиллахаар боллоо.

472.7 тонн хог хаягдлыг цэвэрлэлээ

БОАЖЯ-ны харьяа 21 сав газрын захиргаад орон нутгийнхаа томоохон голын эрэг, булаг шандын ойр орчмыг Байгаль хамгаалах намрын сарын аяны хүрээнд орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран цэвэрлэв. Энэ удаагийн цэвэрлэгээний ажилд 15654 хүн, 442 байгууллага оролцож, 472.7 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн байна. Мөн УИХ-аас 2016 онд баталсан Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох журам”, “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” зэрэг журмуудыг боловсруулан батлуулахад бэлэн болгоод байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээг тэлэх бэлтгэл ажлыг хангав

Улсын тусгай хамгаалалтаар авах 9 аймгийн 29 сумын 3,8 сая га талбайг хамарсан нийт 22 газрыг улсын тусгай хамгаалалтаар дагварчлалд авч оруулж бэлтгэл ажлыг хангалаа. Эдгээр газрыг улсын тусгай хамгаалалтад авснаар тусгай хамгаалалттай нийт газар нутгийн талбайн хэмжээ 32.2 сая га-д хүрч, Монгол Улсын нийт газар нутгийн 20.5 хувийг эзлэх юм. Мөн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, үзэл баримтлалыг батлуулахаар ажиллаж байна. Мөн 2016 онд хамгаалалтад авсан Ноён уул, Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж батлуулах, АНУ зэрэг гадаад орны хамгаалалттай газар, үндэсний паркттай хамтын ажиллагааг өргөжүүлж, менежментийн шинэ арга барил эзэмших ажлуудыг хийж байна.

Самар түүж бэлтгэх зөвшөөрлийн хугацааг наашлууллаа

Энэ жил самрын болц эрт гүйцсэн учраас холбогдох мэргэжлийн байгууллагуудын судалгаа дүгнэлтийг үндэслэн хуш модны самрыг 9 дүгээр сарын 10-наас түүж бэлтгэх БОАЖ-ын сайдын тушаал гаран хэрэгжиж байна. Самар түүж бэлтгэх зөвшөөрлийн хугацааг наашлуулснаар эдийн засаг хямарсан нөхцөлд ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагын орлогын эх үүсвэрийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх боломж олголоо.

Ногоон хөгжлийг мэдлэг түгээв

БОАЖЯ-ны зүгээс энэ онд тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл баримтлал, суурь зарчмуудыг таниулах, мэдлэг олгох чиглэлээр нэлээд эрчимтэй ажиллаж байна. Тухайлбал, 21 аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүд, бусад төрийн байгууллагын төлөөлүүд, хэвлэл мэдээллийн ажилтан, иргэний нийгэм, орон нутгийн иргэдийн оролцуулж нийт 63 удаа, 1520 гаруй хүнийг хамарсан сургалт, семинарыг зохион байгууллаа. Үүнээс 800 гаруй хүнийг хамарсан сургалтыг Засгийн газрын 100 хөногийн хугацаанд зохион байгуулаад байна. Мөн БОАЖЯ, Тогтвортой хөгжлийн төсөл хамтран Ногоон бизнесийг хөгжүүлэх “GREENING BUSINESS DNA” форумыг зохион байгууллаа. БОАЖЯ-наас үйлдвэрлэл, бизнесийг байгальд ээлтэй ногоон хөгжил рүү шилжүүлэх бодлого, хууль тогтоомж боловсруулж батлуулахын зэрэгцээ практик үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал, ногоон барилгын үндсийг тавьж сургууль, цэцэрлэгийн жишиг ногоон барилгын зураг төсөл боловсруулж байгуулах, тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг дэмжиж, ногоон эзэлийн сан, татварын хөнгөлөлт зэрэг эдийн засгийн хошуурийг бий болгох, ногоон хөгжлийн мэдлэг боловсрол олгох, хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн төслийн санал боловсруулж Уур амьсгалын ногоон санд хандах зэрэг ажлыг холбогдох яамд, бизнес эрхлэгчид, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

ЭДИЙН ЗАСАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Ч.ЧУЛУУН

АМГТГ-ын нүүрсний хэлтсийн дарга асан Б.Алтсүхтэй ярилцлаа. Нүүрсний салбарын бодлого, чиг хандлагыг сүүлийн 20 гаруй жил тодорхойлж яваа түүнтэй ярилцаж суухад олон зүйлийг мэдэж авснаа нуух юун.

-Тантай уулзахаар ирж явах замд “Монгол Улс ингэхэд нүүрсний нөөцөө бүрэн тогтоож чадсан юм болов уу” гэх бодол төрсөн. Тиймээс асуултаа үүнээс эхлээ?

Монгол Улс газрын хэвлийн баялгаа бүрэн судалж, нөөцийг нь тогтоож чадаагүй байгаа шүү дээ. Нүүрс ч ялгаагүй. Тиймээс хайгуулын тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгжүүдэд олгож, тэр хэрээр нөөцөө тогтоож авахыг чухалчилдаг. Гэхдээ ашигт малтмалын нөөцөө төрийн тусгайлсан бодлогоор тогтоох ёстой гэж энэ салбарт олон ажил ажиллаж байгаа хүний хувьд боддог. Нөгөөтэйгүүр, газрын доорхи баялгийн нөөцийг бүгдийг нь илрүүлэн тогтоож, хөрөнгө оруулагчдыг татах нь зөв гэж ярьдаг хүмүүс байдаг ч улсын эдийн засаг, хүн амынхаа хэрэгцээндээ тохируулан ашиглах нь чухал болов уу. Монгол Улс 173 тэрбум тонн нүүрсний нөөцтэй. Таамаг байдлаар гэдгийг ойлгох хэрэгтэй. Үүнээс энэ оны эхний есөн сарын байдлаар 38.4 орчим тэрбум тонн нүүрсний нөөцийг нарийвчилсан хайгуулаар хийж, улсын бүртгэлд бүртгүүлсэн. Мөн жилдээ 20 орчим тонн сая нүүрс олборлодгоос дотоодын хэрэгцээ болох эрчим хүчний салбарт найм орчим сая тонныг зарцуулдаг. 2016 оны тухайд эхний есөн сарын байдлаар 16.2 сая тонн нүүрс



Б.АЛТСҮХ:

ДӨРВӨН УУРХАЙ НЭГ ЗАМААР НҮҮРСЭЭ ЭКСПОРТОЛЖ БАЙГАА НЬ ҮНЭ УНАХ ШАЛТГААН БОЛСОН

–Монгол Улс 1500 жил ашиглах нүүрсний нөөцтэй–

экспортлож, 21.3 сая тонн нүүрс борлуулсан гэх дүн мэдээ ширээн дээр минь байна. Тэгэхээр жилд 20 гаруй сая тонн нүүрс олборлодог гээд төсөөлөхөөр өнөөдрийн хэрэглээний түвшингээр манай улс 1500 жилийн нөөцтэй байна гэсэн үг. Ер нь бол бидэнд хайгуул хийгдэж буй талбай олон бий. Төгсгөлд нь нэг зүйлийг онцолж хэлэхэд, бид нөөцөө хангалттай тогтоочихсон. Тиймээс тогтоосон нөөцөө ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах явдал чухал байна шүү дээ.

-Тантай санал нэг байна. АМГТГ 2016 оны эхний есөн сарын байдлаар эхнээн аж ахуйн нэгжид хайгуулын болон орд ашиглах зөвшөөрлийг олгосон бэ?

Нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 220 гаруй уурхай байдаг бөгөөд улсын комисс хүлээн авч уурхай ажиллуулж болно гэсэн зөвшөөрөлтэй нь 110. Үүнээс 49 уурхай жилд 25-30 сая тонн нүүрс олборлодог. Хэрэв ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 220 гаруй уурхайг бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадвал жилдээ 100 гаруй сая тонн нүүрс олборлох боломжтой. Тэгэхээр Монгол Улс жилд нийт нөөцийнхөө дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээг л ашиглаж байна гэсэн үг.

-Манай улс ямар аргачлалар нүүрснийхээ нөөцийг тогтоодог юм бэ. Миний олж мэдсэнээр орос аргачлалыг олон улсад хүлээн зөвшөөрөх тухайд маргаантай байдаг юм биш үү?

Манай улс Орос аргачлалар явж ирсэн. Сүүлийн жилүүдэд гадны хөрөнгө оруулагчдын тавьж буй шаардлагын дагуу Австралийн жорк аргачлалар нөөцөө боддог болсон. Нүүрсний салбарт дээрх хоёр аргачлалын хооронд зөрүү гарах нь харьцангуй бага байдаг. Учир нь нүүрс бусад ашигт малтмалыг бодвол сая тонноор яригддагийн дээр бусад ашигт малтмалтай харьцуулахад хэд хэдэн онцлог чанартай. Жишээ нь, Монгол Улсын хувьд нүүрс бол үндэсний аюулгүй байдлын хэмжээнд яригддаг стратегийн

түүхий эдийн нэг бөгөөд бид нүүрснээс хамааралтай эрчим хүчийг ашигладаг. Алт болоод бусад ашигт малтмалыг дэд бүтцийг нь хөгжүүлэхгүйгээр олборлож болдог бол нүүрснийг их хэмжээгээр удаан хугацаатай олборлохын тулд заавал дэд бүтэц бүхий уурхай байгуулах шаардлага тулгардаг. Мөн овор хэмжээ ихтэй учир уулын томоохон техникийг ашигладаг, зардал ихтэй бизнес. Тиймээс социализмын үед нүүрсний салбарт төр, засаг анхаарлаа хандуулан агентлаг байгуулж, уул уурхайн инженерийг онгогийн инженер хэмээн тусгайлан бэлтгэдэг байлаа. 2010 оноос нүүрсний салбарын нэр хүнд өсч, олон улсын эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл ч нэмэгдсэн. Харамсалтай нь тэр үед манай улсад нүүрсний талаар баримтлах хэлтэс харьяалагдах мөртөө Эрчим хүчний яам нүүрсний газрыг байгуулж, төрийн өмчит нүүрсний уурхайнуудыг харьяалалдаа авсан байдлыг үзжээтэй. Энэ байдал нүүрс олборлогч уурхайнуудад хүнд туссан. Нэг ёсондоо манай улсын нүүрсний салбар олондирдлагатай болж, тав хуваагдажчихаад байгаа. Шулуухан хэлэхэд, нүүрсний салбар улстөрчдийн лобби болж хувирсан.

-Нүүрсний салбар нэгдсэн бодлогогүй гэж та хэллээ?

Тийм. Манай улсад нүүрсний салбарыг хөгжүүлэх нэгдсэн, зангидсан бодлого гэж алга. Нүүрс хөтөлбөр гэж яригдаж байсан ч тэр нь батлагдаагүй. Дээр дурьдсан нэгэн цул байсан салбарыг тал тал тийш нь тараахаар чинь яаж нэгдсэн хөтөлбөртэй байх юм. Уг нь 2005 оноос “Нүүрс” хөтөлбөрийг дөрөв, таван удаа боловсруулахад миний бие тэр бүхэнд оролцож, санаа бодлоо тусгаж явсан. Анх нүүрсний боловсруулах чиглэлээр хөтөлбөр боловсруулсан ч тэр нь хэрэгжээгүй. Тэгтэл 2008 оноос

БНХАУ руу их хэмжээгээр нүүрс экспортлож, экспортын хэмжээг нэмэгдүүлэх саналыг дахин тавьж, “Нүүрс” хөтөлбөрийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж байсан. Тэр үед ажлын хэсэгт багтсан сайд, дарга нар нь туршлага судлаж байна гээд гадны улс орнуудаар өчнөөн явсан ч үр дүнд хүрээгүй. Ингэж байтал нүүрсний салбар уналтын байдалд шилжсэн тул хөтөлбөр хэрэгжих боломжгүй болсон. Харин өнгөрсөн зуны дунд сараас хойш нүүрсний экспорт сэргэх байдал ажиглагдаж эхэлсэн. Гэхдээ нөхцөл байдал цаашид хэрхэн үргэлжлэхийг хэлж мэдэхгүй байна.

-Нүүрсний салбарт зориулсан хууль байдаггүйн улмаас эдийн засгийн хямралд хамгийн түрүүнд өртсөн байж мэднэ. Та санал нийлэх үү?

Нүүрсний салбарт зориулсан тусгай хууль гэж байхгүйн улмаас эрдэс баялгийн салбарын хуулиар л зохицуулагдаж ирсэн. Үүнийг өмнөх УИХ-ын гишүүд улстөрчүүлэн “Таадагын хөрөнгө оруулагчид манай улсаас гарч байгаагийн учир шалтгаан нь энэ” гээд л өөрийн хуулийг тэдний хүсэлд нийцүүлж батлах гэж эзэлээс хамаарч орж, гарч байгаа үүнийг шалтаг гэж харж байгаа. Миний бодлоор, гадаадын хөрөнгө оруулагчид дэлхийн зах зээлд хэсэг буюу хэсэг хэрэг. Үнэндээ дэлхийн зах зээлд нүүрс үнэтэй л байх юм бол тэд нүүрсний орд бүхий орнуудын баялгийн хууль, эрх зүйн орчинд нь зохицоод л үйл ажиллагаагаа явуулаа шүү дээ.

-Баяжуулсан нүүрсний стандартыг ямар байгууллага тогтоодог юм бэ?

Баяжуулсан нүүрсний стандартыг Стандартчилал хэмжээлзүйн газар батайдаг. Бид дан ганц нүүрс гэлтгүй үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахдаа хэрэглэгчийг хаан гэж үзэн тэдэнд зориулж үйлдвэрлэх ёстой. Тиймээс монгол нүүрсний худалдаж авах гэж байгаа улс орныг судлах ёстой. Өөрөөр хэлбэл, тэдэнд

баяжуулсан нүүрс үү, түүхий нүүрс үү, эсвэл эрчим хүч гаргах нүүрс үү гэдгийг тодорхойлох ёстой байхгүй юу. Жишээ нь, манайхан нүүрсээ түүхийгээр нь гаргалаа, нэмүү өртөг шингээх байсан юм гэдэг. Гэтэл бодит байдал дээр манай нүүрсийг авдаг ганц улс нь Хятад. Хил гараад нүүрс баяжуулдаг маш олон үйлдвэр бий. Тиймээс баяжуулсан нүүрс гэхээсээ илүүтэй түүхий нүүрсийг авч өөрсдөө баяжуулах сонирхол тэдэнд ашигтай бус уу. Түүнчлэн гангийн үйлдвэртээ дан ганц баяжуулсан нүүрсийг хэрэглэдэггүй бөгөөд өөрсдийнхөө нүүрсстэй хольж чанарын түвшинг нь тэнцэтгэж үйлдвэрлэлээ явуулдаг юм билээ.

-Чалкогийн өрөөс болж, монгол нүүрс австрали нүүрсний өмнө бөхийх болсон гэж би хувьдаа ойлгоод байгаа?

Нүүрсний чанар болон нүүрс хаанаас ирж байгаагаас шалтгаалан үнэ нь олон янз. Жишээ нь, монгол нүүрс Хятадын хил хүртэл нэг үнэтэй, түүнээс цаашиг нь хятадууд тогтоодог. Тодруулж хэлбэл, шат дамжлагаасаа хамаардаг. Үүнд нүүрсний зардал, ажиллах хүч ч хамааралтай. Гэтэл манайхан нүүрсний үнэ австрали нүүрсний үнэтэй харьцуулж байгаа нь буруу. Австрали улс Хятадын зах зээл рүү өөрсдийн тавьсан замаар, өөрийн хөрөнгө техник хэрэгслээрээ нүүрсээ экспортлодог. Манайд нөхцөл байдал тэс өөр. Бид урд хөрснийхөө тавьсан замаар, тэдний тэвэрийн хэрэгслээр нүүрсээ экспортлодог гэдгээ мартаж болохгүй. Тиймээс бид Хятадын зах зээл дээр байр сууриа олж чадахгүй байгаа юм. Тэр утгаараа Австрали улсыг өөрсөдтэйгөө харьцуулах нь тэнэг хэрэг. Манай улсын эрдэс баялгийн салбар төрийн нэг цонхны нэгдсэн бодлоготой байж гэмээг байр сууриа эзлэх нь зүйн хэрэг. Харамсалтай нь бодлого байхгүй, биржгүйн улмаас өнөөдөр өмнөх жилүүдийн

адил л нүүрсээ Чалкоогоос зээлсэн өрөндөө өгөөд сууж байгаа. Аж ахуйн нэгжүүдийн тухайд өөр хоорондоо өрсөлдөөд л үнээ бууллаад байгаа юм билээ.

-Ингэхэд та урд хөрснийхөө нүүрсний нөөцийг сонирхсон л байлгүй?

Хятад улсын одоо байгаа нөөц нь 40 жил. Үүнийгээ ч олон улсын хурал дээр онцолсон.

...Манай улс Орос аргачлалаар явж ирсэн. Сүүлийн жилүүдэд гадны хөрөнгө оруулагчдын тавьж буй шаардлагын дагуу Австралийн жорк аргачлалаар нөөцөө боддог болсон. Нүүрсний салбарт дээрх хоёр аргачлалын хооронд зөрүү гарах нь харьцангуй бага байдаг. Учир нь нүүрс бусад ашигт малтмалыг бодвол сая тонноор яригддагийн дээр бусад ашигт малтмалтай харьцуулахад хэд хэдэн онцлог чанартай...

Да.Ганболд, Хашчулуун нар ажиллаж байсан санагдана?

Дэлхийн улс орнууд нүүрсийг шингэрүүлж шингэн түлш гаргаж тэр нь онол, туршилтын хувьд батлагдсан. Гэсэн ч үйлдвэрлэлд нэвтрүүлж шингэн түлш гаргасан улс орон байхгүй л байна. Нүүрсийг хийжүүлж цахилгаан эрчим хүч гаргах нь боломжтой ч өртөг өндөр, мэргэжилтэй боловсон хүчин дутмаг учраас тэгсхийгээд зогссон. Занар ч ийм л замаар яваа. Занарыг нүүрс шиг шууд шатааж ашиглах боломжгүй илчлэг муутай бүтээгдэхүүн тул заавал нэрж ашигладаг, нарийн технологи бүхий өндөр өртөгтэй түүхий эд. Манай улсын тухайд занараар шоу хийж, нэр төр хөөснөөс цаашгүй. Үүнийг хэлэхэд, хийж чадах энгийн зүйлийг хийхгүй атлаа дэлхий хийгээгүй зүйлийг хийнэ хэмээн харайлгах нь бүтэшгүй асуудал. Жишээ нь газрын тостой улс бүхэн түүхий нефтээ нэрж, экспортлож байна. Гэтэл манайх түүхий эдтэй атал чадахгүй л байгаа биз дээ. Мөн бусад орон цахилгаан станц бариад эрчим хүч үйлдвэрлэж байхад бид тавдугаар цахилгаан станцаа барьж чадахгүй мөртлөө нүүрс химийн үйлдвэр барина гээд дэвхцээд байгааг би хувьдаа ойлгодоггүй. Нүүрс химийн үйлдвэрийг барих нь зөв ч цаг нь болоогүйгээс гадна хөрөнгө мөнгө нь алга байна.

-Эрчим хүчний нүүрсийг дэлхийн зах зээл дээр гаргах тухай яриа чих дэлсэж байсан ч тэгсхийгээд нам жим боллоо.

Ер нь энэ талын судалгаа байна уу?

Коксжих нүүрс үнэ өндөр. Харин эрчим хүчний нүүрс хямд. Манай улсын нүүрсний илэрсэн нөөцийн 80 гаруй хувь нь эрчим хүчний нүүрс байгаагаас гадна Тавантолгойн нүүрсний 60-аад хувь нь эрчим хүчний юм билээ. Тиймээс эрчим хүчний нүүрсийг дэлхийн зах зээл дээр гаргах асуудал яригдах нь зүйн хэрэг. Гэвч тэвэрлэх зам гарц байхгүй нь хүндрэл болж байна. Эрчим хүчний нүүрсийг эргэлтэд оруулах хамгийн зөв хувилбар бол цахилгаан станц барьж, эрчим хүч үйлдвэрлэх явдал.

-Багануурын уурхай нүүрс боловсруулах төсөл хэрэгжүүлэхээр болж байсан. Түүнийг нь мэргэжлийн Засгийн газар дэмжиж байгаа юу?

Багануурын уурхайд Герман, Японы зэрэг олон төсөл яригддаг. Ер нь уурхайнуудад менежментээ сайжруулах, бүтээгдэхүүнээ чанартай болгох, шинэ технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах зэргээр шийдвэл зохих олон асуудал бий. Гэхдээ энэ нь тухайн уурхайг үндсээр нь өөрчлөх томоохон стратегийн төслүүд биш юм.

-Нүүрсний салбарын томоохон төсөл гэвэл ?

Хүрэн нүүрсний уурхайнуудыг түшиглэн цахилгаан станц барих явдал гэж үзэн өнгөрсөн дөрвөн жилд нэлээд хэдэн тусгай зөвшөөрлийг олгосон. Шивээ-Овоо, Багануур, Чандгана, Тэвшийн говь, Бөөрөлжүүт, Цайдам нуурыг түшиглэн цахилгаан станц барих төслүүдийг нэрлэж болно. Гэвч гарын үсэг зурж, ТЭЗҮ-ээ хийх зэрэг шат дамжлагын ажлууд хийгдэж байсан ч хөрөнгө оруулалт хийгээд бодитоор барих ажлууд нь хэрэгжихгүй л байгаа. Одоо хэрэгжиж байгаа томоохон төсөл гэвэл эрчим хүчний Багануур, Шивээ-Овоогийн төслийн станц, Нарийн сухайт, Тавантолгойн экспортлох цахилгаан станцын төсөл л байх шив дээ.

ДЭЛХИЙ

AT&T компани "Time Warner"-ийг худалдан авчээ

АНУ-ын мэдээллийн технологийн аварга AT&T компани Энтертаймент ертөнцийн хамгийн том компани болох "Time Warner"-ыг 85.4 тэрбум ам.доллаар худалдан авахаар тохиролцсоноо албан ёсоор зарлалаа. Ингэснээр асар их хэмжээний контент үйлдвэрлэх боломж бүхий дэлхийн хэмжээний том медиа групп болж байгааг эх сурвалжууд онцолж байна. Мэдэгдэлд өгүүлснээр AT&T компани "Time Warner"-ийн нэгж хувьцаа бүрт 107.50 ам.доллар төлж, бэлэн мөнгө, хувьцаа нийлээд 85.4 тэрбум ам.долларын дүнтэй наймаа хийхээр болсон байна. Худалдан авах ажиллагаа 2017 онд багтаж дуусахаар төлөвлөгдсөнийг AT&T мэдээлжээ.

AT&T бол Америкийн хоёр дахь том үүрэн холбооны оператор бол Time Warner нь HBO, CNN, Cartoon Network, Warner Brothers зэрэг олон медиа сувгуудыг эзэмшдэг томоохон компани тул энэ наймаа зах зээлд монопол тоглогч гарч ирэх вий гэсэн айдас төрүүлж байгаа юм. Үүний илрэл болж Бүгд Найрамдах Намаас ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Дональд Трамп уг наймааг "хэт их хүч чадал нэг дор төвлөрсөн явдал" гэж нэрлээд "Ардчиллыг устгах аюултай" хэмээн дүгнэсэн байна. Наймааны үр дүнд AT&T компанид Harry Potter, Batman киноны франчайз, The Big Bang Theory, Game of Thrones зэрэг үнэ цэнтэй контентуудыг эзэмших эрх нээж өгч байгаа юм. Түүний өрсөлдөгч Verizon компани мөн медиа салбарт мөнгө хаяж Yahoo-г худалдан авахаар болсон байдаг.

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Н.ЗОРИГ: ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХИЙГ ЗОРЬЖ АЖИЛЛАНА

Н.БАТЗАЯА

Автотээврийн үндэсний төврийн Чанарын удирдлагын албаны дарга, Монгол Улсын Гаавьт тээвэрчин Н.Зоригтой ярилцлаа.

Жилбүрүламжлалболгон зохион байгуулдаг "Өвөлд бэлэн үү" үйл ажиллагаа боллоо. Энэ жилийн хувьд ямар онцлогтой болов?

Авто тээврийн үндэсний төвөөс жил бүрийн аравдугаар сард "Өвөлд бэлэн үү" өдөрлөгийг зохион байгуулдаг. Энэ жилийн өдөрлөг нэлээд өргөн цар хүрээтэй боллоо. Учир нь бид улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал болон тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын гарааш, засварын газрууд өвөлжилтийн бэлтгэлийг хэрхэн хангасан байдлыг шалгах асар гадна Автотээврийн үндэсний төвөөс хийж хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээг иргэдэд сурталчлах, танин мэдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан юм. Ер нь манай байгууллагаас улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг байнга хянаж, шалгалт хийдэг л дээ. Гэхдээ "Өвөлд бэлэн үү" нэгдсэн арга хэмжээний хүрээнд улам баталгаажуулж шалгадаг. Мөн энэ жил хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэгдэж байгаа, 43 шинэ автобус ирсэн. Гэхдээ хараахан үйлчилгээнд явж эхлээгүй байна. Ойрын хугацаанд хот хоорондын үйлчилгээнд явж, иргэдэд үйлчилж эхэлнэ.

"Өвөлд бэлэн үү"



БНХАУ дипломат ялалт байгууллаа

Б.ДАВААХҮҮ

БНХАУ-ын Өмнөд Хятадын тэнгис дэх маргаантай байдаг хөрш зэргэлдээ улсуудын нэг нь Филиппин. Тиймээс Филиппиний "Шийтгэгч" хочиг Родриго Дутертегийн өнгөрсөн долоо хоногт БНХАУ-д хийсэн айлчлал дэлхий нийтийн анхаарлын төвд байлаа. Өнгөрсөн зургадугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулан Филиппиний Ерөнхийлөгч болсон Родриго Дутерте албан тушаалаа авсан даруйдаа хар тамхины эсрэг томоохон хэмжээний дайныг эхлүүлснээс хойш өнөөдрийн байдлаар 3700 гаруй хүн амиа алдсан гэсэн тооцоо бий. Түүний эхлүүлсэн хар тамхины эсрэг дайнаар олон хүний амь эрсдэж буй ч АНУ тэргүүтэй барууны орнууд шүүмжилж ирсэн байх бөгөөд энэ асуудлаас үүдэлтэйгээр Филиппин АНУ-ын харилцаа хөндийрч, ОХУ, БНХАУ-ыг түшиж, тусламж авах сонирхлоо илэрхийлэх болсон байдаг. Тухайлбал,

хэлэх гэсэн үгээ ил шулуухан илэрхийлчихдэг Ерөнхийлөгч эр АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамаг зүй бус үгээр гутаан доромжилсны зэрэгцээ жил бүр уламжлал болгон хийдэг АНУ, Филиппиний цэргийн хамтарсан сургуулийг нь энэ жилээр дуусгавар болгохоо мэдэгдээд байгаа билээ.

Түүнчлэн, Ерөнхийлөгч болсноос хойшхи анхны гадаад айлчлалаа БНХАУ-д хийсэн нь ч олны анхаарлыг ихээр татсан юм. Родриго Дутертегийн манай өмнөд хөршид хийсэн айлчлал өнгөрөгч мягмар гарагт эхэлж, баасан гарагт өндөрлөсөн. Харин энэ удаагийн айлчлалын

хамгийн анхаарал татсан асуудал нь Родриго Өмнөд Хятадын тэнгис дэх хилийн зааг хязгаарыг тогтоох асуудлаарх хоёр улсын хэлэлцээрийг дахин сэргээн хэлэлцэхэд санал нэгдсэн явдал байлаа. Нидерландын Гааг хотод болсон Арбитрын шүүх хурлаар Хятадын Өмнөд Хятадын тэнгис дэх бүрэн эрхт байдлыг үгүйсгэсэн шийдвэр гаргасан удаатай. Харин хоёр улсын төрийн тэргүүнүүд уг асуудлаарх хэлэлцээрийг дахин сэргээхээр тохиролцсон нь "Хятадын хувьд дипломат ялалт боллоо" хэмээн эх сурвалж онцолж байна. Филиппиний Ерөнхийлөгч Родриго Дутерте Хятадад

айлчлах үедээ Азийн хамгийн том гүрнээс эдийн засгийн дэмжлэг хүсч, улмаар удаан хугацаанд холбоотон байсан АНУ-аас "салж" буйгаа мэдэгдсэн юм. Тэгвэл Р.Дутерте айлчлалынхаа сүүлчийн өдрийн хамтарсан мэдэгдэлдээ "Өмнөд Хятадын тэнгист үүссэн өнөөгийн нөхцөл байдал болон бусад асуудлаар тогтмол уулзалт хийж байхаар тохиролцсон нь хоёр улсад ашиг тусгаа өгөх нь гарцаагүй" гэдгийг онцолсон юм.

Олон жилийн өмнө зогссон хоёр улсын хамтарсан далай, тэнгис дэх улсын хил хязгаарыг тогтоох асуудлаарх уулзалтыг ийнхүү дахин сэргээсэн нь БНХАУ-ын хувьд баярлуулжтай үйл явдал болсон гэж ажиглагчид дүгнэж байна. Учир нь Хятад Өмнөд Хятадын тэнгис дэх хилийн маргааны улмаас олон улстай шууд хэлэлцээр хийх боломжгүй байжээ. Тиймээс энэ талаарх яриа хэлэлцээр урт хугацаанд сунжирч байсан аж. Харин

энэ удаагийн Филиппиний Ерөнхийлөгчийн тус улсад хийсэн айлчлалаар эдийн засгийн хувьд бүс нутагтаа тэргүүлэгч Хятад улсын хувьд маргаанд оролцогч талуудтай шууд зөвлөлдөх боломжтой болсон нь нөлөөллөө тэлэхэд нь ашгаа өгөх нь гарцаагүй. Гэхдээ айлчлалын үеэр аль аль тал нь Олон улсын Арбитрын шүүхийн шийдвэрийн талаар дурьдсангүй. Тус шүүхээс энэ онд Өмнөд Хятадын тэнгисийн ихэнхи бүс нутгийг БНХАУ эрх зүйн үндэслэлгүйгээр эзэмшилдээ оруулсан гэж шийдвэрлэсэн байдаг. Харин Хятадын тал уг шийдвэрийг хүчтэй эсэргүүцэж буйгаа илэрхийлж байсан билээ.

өдөрлөгт хэчнээн аж ахуйн нэгж оролцов. Энэхүү өдөрлөгийн хүрээнд нийтийн тээврийн хэрэгсэлд шалгалт хийдэг гэлээ. Энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлахгүй юу?

Хүнд үйлчилдэг учраас улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэл байнгын хяналтад байдаг. Хуулийн дагуу нийтийн тээврийн хэрэгсэл жилд хоёр удаа техникийн хяналтын үзлэгт ордог юм. Харин манай байгууллагаас улирал болгон техникийн хяналтын үзлэгийг хийж байна. Манайхаас нэмэлтээр зохион байгуулж байгаа үзлэгийг төлбөргүй хийдэг. Тэгэхээр тухайн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг байнга шалгадаг гэсэн үг. Харин өвөлд бэлэн үү өдөрлөгийн хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагууд техникийн бүрэн байдлаас гадна өвлийн улиралд зориулж нэмэлт ямар арга хэмжээ авч бэ гэдгээ тайлагнадаг. Тухайлбал, зуны дугуйгаа сольж өвлийн болгох, өөрт хэрэгтэй ойр зуурын сэлбэг хэрэгсэлээ базаах, цас ихтэй үед машинаа чирэх техникийн түргэн тусламжийн машинныхаа бэлэн байдлыг хангах гэх мэтчилэн тухайн улиралд зориулж бэлтгэлээ хангадаг. Мэдээж ямар нэгэн гэнэтийн зүйл тохиолоход жолооч бэлтгэлтэй байх ёстой.

Шинэ Засгийн газар гарсантай холбогдуулан 100 хоногт хийсэн ажлаа ард иргэддээ тайлагнах ажил эд өрнөж байна. Танай байгууллагын хувьд ямар ажил хийв?

Шинэ Засгийн газар байгуулагдаад 100 хоног нь боллоо. Энэ хүрээнд бид хэд хэдэн ажлыг хийсэн.

Нэгдүгээрт, Тяньжин боомт хотоос Монгол Улсын газар нутгаар дайран ОХУ-ын Улаан-Үд хот хүрэх транзит тээврийн туршилтыг өнгөрсөн наймдугаар сард амжилттай хийлээ. Монголын тээвэрчид энэхүү үйл ажиллагаанд оролцох учраас

...Улс, хот хооронд нийт 1000 гаруй тээврийн хэрэгсэл үйлчилдэг. Эдгээр тээврийн хэрэгсэлд байршил тогтоох төхөөрөмж суурилуулсан. Байршил тогтоох төхөөрөмжийн тусламжтайгаар хөдөлгөөний удирдлагын төвөөс хянах боломжтой. Тухайлбал, хаана явж байгаа, ямар нэгэн эвдрэл гэмтэл гарсан эсэхийг мэдэж болдог. Одоогийн байдлаар улс, хот хоорондын тээврийн хэрэгслийг хянаж байна...

маш ач холбогдолтой ажил болсон. Хоёрдугаарт, Дорнод аймгийн төвөөс ӨМӨЗО-ны Манжуур хот хүртэл нийтийн тээврийн үйлчилгээний шинэ шугам нээгдэж байна. Одоо үйлчилгээнд явах тээврийн хэрэгслүүдээ сонгож байна. Энэ арваннэгдүгээр сард

багтаад Дорнод аймгийн төвөөс Манжуур хот хооронд байнгын нийтийн тээвэр явж эхэлнэ. Ер нь манай тээврийн салбар сүүлийн 20 жилд маш ахиц, дэвшилтэйгээр хөгжиж байна. 2000 онд Монгол Улсад 100 мянган тээврийн хэрэгсэл байсан бол эдүгээ 800 мянган тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Манай улсад олон улс орны орчин үеийн дэвшилтэд тээврийн хэрэгсэл орж ирж байна. Тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгын хүрээнд техникийн үзлэгийн хяналтыг 2000 оноос эхэлж хэрэгжүүлсэн. 2005 оноос энэ үйл ажиллагааг байнгын болгосон. Одоо бид техникийн хяналтын үзлэгийг олон улсын жишигт хүрэхийн тулд ISO стандартын дагуу итгэмжлэлд хамруулах ажлыг эхлүүлж байна. Ингэснээр манай техникийн хяналтын төвийн үзлэгт хамрагдаж стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл олон улсад зөвшөөрөгдөнө. Өөрөөр хэлбэл, бид олон улсын төвшинд үйл ажиллагаагаа явуулж эхэлж байна гэсэн үг. Бид зөвхөн тээврийн хэрэгслийн техникийн хяналт гэлтгүй авто тээврийн чиглэлээр явагдаж буй үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхийг зорьж байна.

Авто тээврийн үндэсний төв мэргэшсэн жолоочийг бэлтгэдэг. Энэ жил хэчнээн жолооч бэлтгэсэн бэ. Цаашид транзит тээвэрт явах жолооч нарыг бэлтгэх үүрэг ногдож байх шиг байна?

Авто тээврийн тухай хуульд 2008 онд өөрчлөлт оруулж, жолоочийн талаарх заалтыг оруулсан. Нийтийн тээврийн

үйлчилгээний хэрэгсэл, хүнд даацын тээврийн хэрэгсэл, авто машинаар ажил үйлчилгээг эрхэлж орлого олдог жолооч бүхэн мэргэшсэн байна гэж хуульд заасан. Үүний дагуу 2008 оноос өмнө жолооч болсон хүн тухайн ангиллаараа шалгалт өгч шууд мэргэшсэн үнэмлэх авч болно. Харин 2008 оноос хойш жолооч болсон хүн заавал сургалтад хамрагдаж мэргэшсэн жолоочийн үнэмлэх авах ёстой. Нийслэл болон хөдөө орон нутгийн аймгийн төвд тодорхой хэмжээний авто сургуулиуд бий. Тэнд сургалтад хамрагдан Авто тээврийн үндэсний төвд ирж шалгалт өгнө. Нэг үгээр хэлбэл жолооны курсууд сургалт явуулж, манай байгууллага шалгалтыг нь авах юм. Шалгалтад тэнцсэн тохиолдолд үнэмлэх олгодог.

Улс хоорондын тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх нэлээд хугацаа өнгөрсөн. Одоогийн байдлаар хэчнээн улс руу нийтийн тээвэр явж байна вэ?

Одоогийн байдлаар гурван улс руу нийтийн тээвэр явж байна. Тодруулбал, ОХУ, БНХАУ, Казакстан улс руу гурван аж ахуйн нэгж байгууллагын нийт 40 гаруй автобус явдаг.

Танай хөдөлгөөний удирдлагын төвөөс улс, хот хооронд явж байгаа тээврийн хэрэгслийг GPS төхөөрөмжийн тусламжтайгаар хянадаг шүү дээ. Цаашид энэ төхөөрөмжийн хэрэгслээг өргөжүүлэх шаардлагатай юу?

Улс, хот хооронд нийт 1000 гаруй тээврийн хэрэгсэл үйлчилдэг. Эдгээр тээврийн хэрэгсэлд байршил тогтоох төхөөрөмж суурилуулсан. Байршил

тогтоох төхөөрөмжийн тусламжтайгаар хөдөлгөөний удирдлагын төвөөс хянах боломжтой. Тухайлбал, хаана явж байгаа, ямар нэгэн эвдрэл гэмтэл гарсан эсэхийг мэдэж болдог. Одоогийн байдлаар улс, хот хоорондын тээврийн хэрэгслийг хянаж байна. Ер нь аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүс машиндаа GPS төхөөрөмж суурилуулж манай байгууллагатай холбоод өөрсдөө хянах боломжтой. Хамгийн энгийн жишээ дурдъя л даа. Түргэний машин дуудлага аваад явахдаа хаана явж байгаа нь мэдэгддэггүй шүү дээ. Дуудлага өгсөн айлдаа очсон уу, түгжрээд явж байна уу, айлаа олохгүй төөрч байна уу гэдэг нь тодорхойгүй байдаг. Хэрвээ байршил тогтоох төхөөрөмж суурилуулчихвал дуудлага өгсөн хүн, явуулсан байгууллага нь ч машинаа хаана явж байгааг нь мэдэх боломжтой. Хот тохижилтийн машин ч энэ төхөөрөмжийг суурилуулах бүрэн боломжтой. Одоохондоо бид машины хурд, байршлыг хянаж байна. Цаашид машинныхаа жин, шатахууны зарцуулалт, ямар бараа явж байгааг хүртэл камерын систем ашиглаж хянах нөхцөл нь бүрдсэн. Үүнийг нэвтрүүлэхийн төлөө зорьж ажиллаж байна.

Цаашид хэрэгжүүлэх ажлаасаа сонирхуулахгүй юу?

Манай байгууллагын хувьд олон ажлыг хийх шаардлагатай байна. Техник технологийн асар хурдтай хөгжиж байгаа нийгэмд техникийн хурдаас хоцорч, хуучин арга барилаар ажиллах нь тохиромжгүй. Тэгэхээр энэ чиглэлээр нэлээд үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгтэй. Бидний үйл ажиллагаа эхнээсээ ухаалг системд шилжиж байна. Бид

ШУУРХАЙ МЭДЭЭ

ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУДЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГТЭЙ

Н.БАТЗАЯА

Эрүүл мэндийн салбарын эрх зүйн ойлголтыг судалж, тухайн салбарт гарч буй эрх зүйн зөрчлийг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлж байгаа залуу боловсон хүчин “Эрүүл мэнд, эрх зүй” төвийн тэргүүн Хүний их эмч, Эрх зүйч Б.Одгэрэлээс Монголын эмч, эмнэлгийн ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэг ямар байгаа, цаашид хэрхэх шаардлагатай талаар зарим зүйлийг тодрууллаа.

-Эмнэлгийн эрх зүй гэж юуг хэлэх вэ. Бие даасан ойлголт бий юу?

Эмнэлгийн эрх зүй гэх нэр томъёо шинэ мэт сонсогдож байгаа боловч бидний амьдралд аль эрт бий болсон эрх зүйн нэг төрөл юм. Тэгэхээр эмнэлгийн эрх зүй гэж эрүүл мэндийн салбар, эмч, эмнэлгийн мэргэжлийн ажилтан албан хаагчидтай холбогдон гарч буй бүхий л эрх зүйн харилцааг хэлнэ. Тухайлбал, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, журам, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, энэ салбарын хөдөлмөрийн эрх зүй, донор, зөвлөнгүй үхүүлэх буюу эвтаназийн асуудал, эмчийн ёс зүйн тухай гээд маш өргөн хүрээтэй ойлголтууд энд багтдаг.

-Манай улсын эмч, мэргэжилтнүүдийн энэ талаархи хуулийн мэдлэг хэр байдаг вэ?

Бусад улс оронтой харьцуулахад, тэр тусмаа өндөр хөгжилтэй орны эмч нарын хуулийн мэдлэг маш өндөр байдаг. Тэд хууль эрх зүйн зөрчлийн асуудлаас өөрсдийгөө хамгаалж ажлаа сэтгэл тайван гүйцэтгэх нөхцлийг өөртөө бүрдүүлж чаддаг. Харин манай оронд эмчийн гэмт хэрэг болон үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил цөөнгүй тохиолддог боловч эмч, эрүүл мэндийн салбарын ажилтны хууль эрх зүйн мэдлэг дутмаг байдгаас тухайн нөхцөлд эрхээ бүрэн хамгаалж чадахгүй байна. Мөн хууль хяналтын байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийн салбарын ойлголт сул, эмнэлгийн эрх зүйн мэдлэг тааруу байгаагаас асуудалд үндэслэлгүй хандах нэг шалтгаан болж байна.

Тэгвэл цаашид энэ тал дээр ямар арга хэмжээ авах шаардлагатай юм бол?

Юун түрүүнд эмч, эмнэлгийн ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах нэн шаардлагатай. Тиймээс бид эрүүл мэндийн салбарын эрх зүйн асуудалд зөвлөгөө өгөх, сургалт явуулах “Эрүүл мэнд, эрх зүй” төвийг нээн ажиллуулж байна. Мөн эмч, эмнэлгийн салбартай холбоотой эрх зүйн зөрчилд өмгөөлөл хийх, энэ асуудалд илүү ул суурьтай хандах, туршлагатай өмгөөлөгч нарыг бэлтгэж байгаа. Түүнчлэн эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам гээд бүхий л эрх зүйн актуудыг эмхэтгэн боловсруулж гарын авлага гаргахаар ажиллаж байна.

-Та эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын эмч нарт холбоотой заалтын талаар юу хэлэх вэ?

Бодит байдал дээрх эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа боловсон хүчин, эмч нарын нөхцөлд хатуурхсан заалт боловч уу гэж хувьдаа үзэж байна. Харин цагаан асуудал мэдээж маш чухал. Гэхдээ тухайн заалт нь харилцаагч биш айдас түгшүүрийг нэмж байна уу даа гэж харж байна. Одоогоор Эрүүгийн хуульд өөрчлөлт ороогүй мөрдөгдөх хугацаа хойшилсон. Энэ асуудалд эмч мэргэжилтнүүд ч гэсэн нэлээн нухацтай хандаж байгаа.

PHOTO NEWS



Монголын Уран зургийн галерейн санаачилгаар Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгээр Хараны бэрхизэлтэй хүүхдийн 116 дугаар сургууль, Клей арт керамика студийн хамтран хэрэгжүүлж буй “Аниргүйн мэдрэлж” тэлтрэхүйн төслийн үзэсгэлэнгийн нээлт Уран зургийн галерейн үзэсгэлэнгийн танхимд боллоо. Музейн үзтэр ховор нандин, атархан гэлтэх онцлогтой байдаг учир “Үзэгчид музейн гар хүрч болохгүй” гэсэн хориг аль ч музейд байдаг. Тийлээс хараны бэрхизэлтэй иргэд музей үзэх боломжгүй болдог бөгөөд тэдэнд музей үзэх адила тэгш боломж олгох, хараны бэрхизэлтэй хүүхдүүдийн дүрслэх урлагийн боловсролд хувь нэмэл оруулах, өөрсдийн гараар бүтээл туурвих, түүнийгээ үзэсгэлэнгийн хэлбэрээр бусадтай хуваалцах, олон нийтэд танилцуулах зорилгоор энэ төслийг хэрэгжүүлж буй ажээ.

Зарим аймгийг нийслэлтэй холбох авто замын ажлыг эхлүүлжээ

Зам тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Монгол Улсад шинээр баригдаж буй авто зам, гүүрийн санхүүжилт, барилгажилтын явцын талаар мэдээлэл өглөө. Тодруулбал, Сэлэнгэ аймгийн Ерөө гол дээрх 272.7 метр төмөр бетон гүүр, Улаанбаатар хотын шинэ нисэх буудлыг Өндөр довын жуулчны баазтай холбох 3.8 км, Улаанбаатар Мандалговь чиглэлийн авто замыг Өндөр довын жуулчны баазтай холбох 5.5 км, Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км нийт 39.1 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад шинэ Засгийн газар оруулжээ. Харин Халзан бүргэдэй-Солонготын даваа чиглэлийн үлдэгдэл 58 км, Цахир-Тосонцэнгэл чиглэлийн авто замын үлдэгдэл 120 км, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын үлдэгдэл 77.8-ийг тус тус хэсэгчлэн, мөн Элсэн тасархай-Орхоны гүүр чиглэлийн 77 км, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9.8 км нийт 342.6 км хатуу хучилттай авто зам болон Хэнтий аймгийн Баянмөнх сумын Хэрлэн голын 217.2 метр бетон гүүрийн ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа юм байна. БНХАУ-ын

Засгийн газрын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Завхан аймгийн төвийг нийслэлтэй холбох зам, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Говь-Алтай аймгийн төвийг нийслэлтэй холбох замын хэсэг болох Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто замын барилгын бэлтгэл ажлыг хангаж, зам барилгын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна хэмээн Д.Ганбат сайд мэдээллээ. Мөн Улаанбаатар-Хөшигийн хөндийн чиглэлийн 32.3 км хурдны замын 0-12 км дэх замын барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг авч гүйцэтгэж байгаа юм байна. Ажлын явц одоогийн байдлаар 30 гаруй хувьтай байгаа гэнэ. Монгол Улсын 2016 оны төсвийн тодотголд улсын чанартай нийт 12,640 км авто зам, түүнд хамрагдах 278 ширхэг гүүрийн арчлалт, засварын ажилд шаардлагатай 12 тэрбум төгрөгийг нэмж тусгуулсан. Уг нэмэлт хөрөнгийг тэдний өмчит 20, хувийн эвшлийн найман зам хариуцагч компанид хуваарилсан байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ЦАС ОРЖ ХҮЙТЭРНЭ

Өнөөдөр ихэнх нутгаар, маргааш зүүн аймгуудын нутаг болон баруун аймгуудын баруун хэсгээр цас орж хүйтэрнэ. Салхи ихэнх нутгаар, 25-26-нд говь, талын нутгаар секундэд түр зуур 16-18 метр хүрч, цасан болон шороон шуурга шуурахыг Ус цаг уурын хүрээлэнгээс мэдээллээ. Тиймээс нийт ард иргэд, жолооч нарт шаардлагагүй тохиолдолд энэ өдрүүдэд орон нутгийн замд гарахгүй байх, мөн гарсан тохиолдолд авто машины бүрэн бүтэн байдлыг сайтар хангаж, хөдөлгөөнд оролцохыг холбогдох албанаас анхаарууллаа.



Тэрэл зургийг Т.АРГУУЖИН

нийтийн тээврийн хэрэгслээ хянах боломжтой болчихлоо. Мөн өмнө нь бид өөрийн биеэр очиж, дугаарлаж автобусны тасалбараа авдаг байсан бол одоо гэртээ компьютерийнхээ ард сууж байгаад л тасалбараа захиалдаг болсон. Жолооч нар машин нь техникийн хяналтын үзлэгт орох хугацаа нь болсон эсэхийг манай вэб сайт руу ороод шалгаж болно. Энэ мэтчилэн техникийн дэвшлийг ашиглаж зарим үйл ажиллагаа маань ухаалаг системд шилжиж байна. Би түрүүнд бас хэлсэн. Цаашид чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхийн төлөө зорьж ажиллах хэрэгтэй. Бид техникийн хяналтын үзлэг хийж байгаа тоног төхөөрөмжүүдээ баталгаажуулах лаборатори байгуулж байна. Техникийн хяналтын үзлэгийн төвүүдээ итгэмжлэлд хамруулна, авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоож, тохирлын үнэлгээ хийлгэнэ. Энэ бүгд бидний зорилт. Ер нь чанартай үйл ажиллагаа явуулъя гэж зорьж байна. Иргэддээ хүрсэн, хүнд сурталгүй үйл ажиллагаа явуулах нь чухал. Машин хүний өдөр тутмын хэрэгцээ хэдий ч цаанаа аюул дагуулж явдаг. Өнөөдөр авто ослын улмаас өндөр бүр хүн нас бардаг боллоо. Энэ бүгдийг

бууруулах хэрэгтэй. Манай улсад зүүн талдаа жолоотой машин ашиглаж байгаа юм. Гэтэл манай улсад явж буй машины 40 гаруй хувь нь баруун талдаа жолоотой болсон. Энэ нь осол, аваар гарахад нөлөөлдөг. Баруун талдаа жолоотой болохоор ямар аюул дагуулж байна вэ гэвэл авто машин шөнө явахад гэрлийн тусгал нь буруу тусдаг юм. Зүүн талдаа жолоотой бол гэрлийн тусгал нь баруун буюу зам тал руугаа тусч урдаас ирж буй машиныг гялбуулдаггүй. Гэтэл зүүн талдаа жолоотой машин замын хөдөлгөөнд оролцож байгаагаас болж урдаас ирсэн машиныг гялбуулдаг, нөгөө талаас баруун талаас ирж байгаа явган зорчигч харагдаггүй. Энэ бүхнээс шалтгаалж авто машины осол гарч байна. Тиймээс энэ асуудал бидний анхаарлыг ихэд татаж, судалгаа хийж байна. Бид зүүн талдаа жолоотой машин оруулж ирэхийг хориглох, эсвэл баруун талын жолооч хэмжээнд ярихгүй бол асуудал аль хэдийн үүссэн байна. Энэ мэтчилэн олон асуудал авто тээврийн салбарт бий. Гэхдээ энэ бүхнийг манай авто тээврийн салбарынхан, инженер техникийн ажилчид шийдвэрлэхийн төлөө л

ажиллаж байна. **-Автомашиньг хилээр сэлбэг гэж оруулж ирээд угсраад зардаг гэсэн асуудал бий. Энэ тал дээр ямар арга хэмжээ авч байна вэ. Танайх улсын бүртгэлийн дугаар олгодог шүү дээ?** Тийм асуудал нэг хэсэг байсан. Бүр задалж, тайрч оруулж ирээд эргүүлээд угсраад дугаар олгодог хөдөлгөөнд оролцдог үе байсан. Одоо бол тийм зүйл байхгүй. Манай байгууллага тийм машинд дугаар олгодоггүй. Бүртгэл хийдэггүй. Бид одоо автомашиньг бүртгэхдээ дандаа арлын дугаараар нь бүртгэж байна. Арлын дугаар дахин давтагдаггүй. Мөн бид бүртгэхдээ гаалийн байгууллагын баримтыг үндэслэдэг. Хэрвээ гаалийн машин гэж орж ирээд татвараа төлсөн тохиолдолд бүртгэж байна. Түүнээс сэлбэг гэж орж ирсэн машиныг бүртгэхгүй. Сэлбэгийг машин гэж бүртгэхгүй. Өмнө нь бид цаасан дээр бүртгэлийн ажлыг явуулдаг байлаа. Тухайн үед цаас нь алга болдог, олддоггүй байх эергээс шалтгаалж дугаар нь давхцаж зэрэг будиалаан үүсдэг байсан. Одоо цахим хэлбэрт оруулсан. Хэрвээ арлын дугаар нь давхцавал систем маань хүлээж авдаггүй юм.

Сурагчдын амралт ирэх сарын 3-нд эхэлнэ

Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц, сурагчдын амралтын хугацаа”-г баталжээ. Ингэснээр хичээлийн жилийн бүтцийг жил бүр өөрчилж ирснийг болуулж 2016-2017 оны хичээлийн жилээс тогтвортой мөрдөхөөр болсон байна. Үүнтэй холбогдуулан БСШУС-ын сайд Ж.Батсуурь 2016-2017 оны хичээлийн жилийн бүтэц, сурагчдын амралтын хуваарийг танилцуулж, мэдээлэл хийсэн юм. Тэрбээр энэ үеэр “Аймаг, сум, тосгон, багийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 4-ний өдрөөс эхлэн долоо хоног амарч байх зохицуулалт хийлээ. Эл зохицуулалтыг хийснээр Монголын уламжлалт цагаан сарын баяр хэзээ болохоос хамааран хичээлийн жилийн бүтэцэд жил бүр өөрчлөлт оруулах шаардлагагүй болж байгаа. Хөдөө, орон нутгийн ЕБС-ийн сурагчдыг мал төлөлтний үеэр амрааж байх зохицуулалтыг хийж, тухайн орон нутгийн мал төлөх хугацаатай уялдуулан шаардлагатай тохиолдолд сурагчдын гуравдугаар улирлын амралтыг нэг долоо хоногийн өмнө эхлүүлэх зөвшөөрлийг холбогдох аймгийн Засаг даргад олгож байна. ЕБС-д гурав болон түүнээс дээш хүүхэд нь бага, дунд, ахлах ангид зэрэг суралцаж хөдөөгийн малчин эцэг эх хүүхдээ улирлын амралтаар авах, хүргэхэд олон удаа ирж очдог хүндрэлийг арилгасан. Улаанбаатар хотын бага ангийн сурагчид хүйтний ид үед гураван долоо хоног буюу арванхоёрдугаар сарын 29-нөөс нэгдүгээр сарын 18-ныг дуустал амарна. Харин хөдөө, орон нутгийн бага ангийн сурагчид хоёр долоо хоног буюу арванхоёрдугаар сарын 29-нөөс нэгдүгээр сарын 11-нийг дуустал амарна. Хот, хөдөөд сурагчдын хичээллэх болон амрах хугацаа нэгэн адил байна” гэлээ.

Эмнэлгүүд нисдэг тэрэгний зогсоолтой болно

“Яаралтай түргэн тусламж”-ийн зорнуулалтаар ашиглах нисдэг тэрэгний зогсоол байгуулах боломжтой байршлуудын судалгааг ЗТХБ-ын сайдын тушаалаар томилогдсон Ажлын хэсгийнхэн гарцаажээ. Тэд нэгдүгээр эмнэлгийн хашаанд шинээр барихаар төвлөж буй зургаан давхар авто машины гараж, Түргэн тусламжийн төвийн ар талд болон Сэлбэ голын эрэг дагуу, ГССҮТ-ийн баруун урд авто зогсоол, зүүн талын сагсны талбай, гуравдугаар эмнэлгийн хойд талын авто зогсоол, Түлэнхийн төвийн барилга дээр, БЗД-ийн АУИС-ийн харьяа бага эмнэлгийн барилгын дээвэр зэрэг газруудыг судалж тохиромжтой гэсэн хоёр байршлыг сонгожээ. Үүний дагуу эхний ээлжид Сэлбэ голын эрэг дагуу болон ГССҮТ-ийн сагсны талбайд нисдэг тэрэгний зогсоол байгуулахаар урьдчилсан байдлаар шийдвэрлэж, цаашид хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан холбогдох газруудад танилцуулахаар болсон байна.

Хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгнө

Нийслэлийн 377 жилийн ойн баярыг тохиолдуулан НЗДТГ, Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран иргэдэд үнэ төлбөргүй хууль, эрх зүйн зөвлөгөө, тусалцаа үзүүлэх өдөрлөгийг ирэх баасан гарагт зохион байгуулна. Тодруулбал, иргэн, хуулийн этгээдэд хуулийн тусалцаа үзүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахад нь туслах, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийг боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хуулийн асуудлаар амаар болон бичгээр зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэх юм. Өдөрлөг нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дунжингарав, Мишээл, Драгон дахь салбаруудад энэ сарын 28-ны өдрийн 10-19 цагт болно.

Авто замын боомт ажиллахгүй

Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр буюу Монгол бахархлын өдөр энэ сарын 31-ний өдөр тохиож буй билээ. Тэгвэл эл өдөр Монгол, Хятадын авто замын хилийн боомтууд ажиллахгүй, амарна. Монгол Улсын нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн 1.8-д жил бүрийн өвлийн тэргүүн сарын шинийн 1-ний өдрийг Их Эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр буюу Монгол бахархлын өдөр хэмээн тэмдэглэж байхаар заасан юм.

ФОТО УРЛАЧ

Хөдөөний намар



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Бидэнд тохиолдсон



Bold Dulamsuren



Багадаа үе үе хөдөө гардаг байлаа. Саалийн ферм дээр зусланд гардаг байсан юм. Хөдөө удахаар хотоос зочин ирсэн айлыг андахгүй агнадаг болдог юм билээ. Наадмын өглөө баруун айлын гадуу машин зогсох чимээгээр санд мэнд босоод л нутгийн хэдтэйгээ уралдаад л орлоо. Айлын эгч атга дүүрэн хишиг хүртээж байна. Би хамгийн урд нь болохоор араасаа шахуулж уначих гээд багана тэврээд зогсож байсан

юм. Авдаг юмаа авчихаад эргэх гэсэн болдоггүй. Аргагүй шүү дээ, хоёр гардаад авсан амтганаа баганаас салгаж чадахгүй сандарч байгаа юм чинь. Тэгээд томчуулаас инээж дууссан нь надад тусалж билээ. Айлын эгч ч зориуд тэгж өгсөн байх. Хамгийн түрүүнд орж ирээд хамгийн сүүлд гардаг байгаа. Битгий багана тэврээд бай гэж загнадаг чинь нийм учиртай юм байна лээ шүү. Ха ха ха.

Улаанбаатарт:

 Маргааш
 Өдөр -4
 Шөнө -13

 Нөгөөдөр
 Өдөр 0
 Шөнө -11

Өдрийн зурхай

Намрын адаг шар нохой сарын Долоон улаан мэнгэтэй Шарагчин туулай өдөр. Сумъяа гараг

Үс засуулбал: Өвчин эмгэг ирнэ
 Наран ургах, шингэх:
 07:28 - 17:55



Өдрийн өнгө: .
 Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эл, этнэлийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тативрыг сүргээх, гарагийг тахиж, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийтөрийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хявас гаргах, уул овоо тахилахд шуу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиаболтой.

Хол газар яваар одогсод ураги төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДУУЛГАХ СОНИН

С.Сарнай олон улсын тэмцээний ТЭРГҮҮН ТИТМИЙН ЭЗНЭЭР ӨРГӨМЖЛӨГДЛӨӨ

Загвар өмсөгч С.Сарнай "Miss & Mrs Asia Noble Queen International" олон улсын тэмцээнд эх орноо төлөөлөн оролцон тэргүүн титмийн эзнээр шалгарлаа. Энэхүү тэмцээний эцсийн шатны шалгаруулалт энэ сарын 21-ний өдөр Малайз улсын Куала Лумпур хотноо болж шилдгүүдээ тодруулсан юм. С.Сарнай "Miss & Mrs Asia Noble Queen International" тэмцээний тэргүүн байрын шагналаас гадна "Popular miss" шагналын эзэн болсон байна.

“ИТГЭЛ” Азийн кино наадамд өрсөлдөнө

Бодит амьдралаас сэдэвлэн бүтээсэн “Итгэл” уран сайхны кино энэ сарын 7-нд нээлттэй хийсэн. “Үхэхийн цагт хүнийг юутай байсныг нь бус хэн байсныг нь л дурсдаг” хэмээн өгүүлэх тус киноны найруулагчаар Б.Гарамханд ажилласан. Харин гол дүрд “холливуд” хочтой Б.Амарсайхан буюу Амаргаа болон “Guys” хамтлагийн М.Мягмар, Ц.Төмөрхуяг нар тоглосон юм. Дэлгэцэнд гарсан цагаасаа үзэгчдээс өндөр үнэлгээ авч буй “Итгэл” кино Азийн дэлхийн шилдэг кино наадамд өрсөлдөх гэнэ.

Тодруулбал, өнөөдөр “Oscar”-ын шагналт, нэрт продюсер Андре Морган, “Hollywood School house”-ийг үүсгэн байгуулагч Феррис Вебе, Лос Анжелес хотын амбан захирагч Антонио Вилларайгоса зэрэг олон улсад нэр хүндтэй уран бүтээлчид, нийгмийн зүтгэлтнүүд хүндэт гишүүнээр тус, тус сонгогдон ажилладаг “Азийн шилдэг кино наадам”

эхэлнэ. “Азийн шилдэг кино наадам” нь Азийн улс орнуудын ахуй соёл, ёс заншил, өвөрмөц онцлогийг кино урлагаар дамжуулан дэлхий дахинаа таниулан сурталчлах зорилготой юм.

Тус наадамд Ази тивийн 50 гаруй орны кино уран бүтээлчид оролцож долоон номинацид хоорондоо өрсөлддөг бөгөөд тухайн бүтээлүүд дунд тухайн оны Оскар болон Алтан бөмбөрцөг кино наадамд өрсөлдөх кинонууд оролцдоггоороо онцлогтой. Кино бүтээгчдийг хооронд нь танилцуулах цаашдаа хамтран ажиллах боломжийг нээх төдийгүй Азийн кино уран бүтээлчийг Холливудад танигдах боломжийг нээдэг уг наадамд өнгөрсөн жил “Бодлын хулгайч” кино “Үзэгчдийн таашаалд нийцсэн бүтээл” шагналыг хүртсэн бол энэ жил Монгол улсаас “Итгэл”, “Ээж” уран сайхны кинонууд оролцохоор болжээ.

А.Баярцэцэг “ДЭЛХИЙН МИСС”-Т ЭХ ОРНОО ТӨЛӨӨЛНӨ

“Миний эхнэр тагнуульч”, “Марко поло”, алдарт найруулагч Кристофер Копполагийн “Deadbeats” тэргүүтэй олон шилдэг кинонд туслах дүр бүтээсэн авьяаслаг жүжигчин бол А.Баярцэцэг. Түүнийг жүжигчин гэдгээр нь хүмүүс андахгүй. Тэгвэл тэрбээр дэлхийн хамгийн үзэсгэлэнтэй бүсгүйчүүдийг шалгаруулдаг “Miss world 2016” тэмцээнд ирэх арванхоёрдугаар сард эх орноо төлөөлөн оролцохоор боллоо. Үзэсгэлэн гоо, авьяас билэг, мэдлэг оюуныг хослуулсан Алтангэрэлийн Баярцэцэг “Miss world Mongolia”-гийн ялагчийн титмийг гардсанаар ийнхүү “Дэлхийн мисс”-т эх орноо төлөөлөх эрхтэй болсон юм. 1951 оноос зохион байгуулагдаж буй Дэлхийн миссийн тэмцээнд манай улс 2005 оноос үндэсний гоо бүсгүйгээ оролцуулж эхэлсэн түүхтэй. Энэ жил 12 дахь удаагаа А.Баярцэцэгийг илгээх гэж байна. “Miss world” бол хамгийн олон орны бүсгүйчүүд оролцдог цар хүрээгээрээ дэлхийд тэргүүлдэг гоо сайхны олимп билээ.



ТЭНГИС КИНО ТЕАТР

УНЭ ТӨЛБӨРГҮЙ

Бүрэг Найрамдах Турк Улс тунхагласны 93 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, тус Элчин сайдын яамны олон нийтэд нээлттэй дипломат амжиллагааг гэмжих зорилгоор Туркийн кино найруулагч Зүлфү Ливанелигийн 2010 оны бүтээл “Салах ёс” уран сайхны киног 2016 оны аравдугаар сарын 25, 29-ний өдрүүдэд 19:30 цагаас “Тэнгис” кино театрт үзүүлнэ.

